

Монгол Улсын Засгийн газар

**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХ, ОРОЛЦООГ
НЭМЭГДҮҮЛЭХ, ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР
(2017-2020)**

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	2
УДИРТГАЛ	4
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	6
1.1 Тулгамдаж байгаа асуудал, нөхцөл байдлын дүн шинжилгээний гол үр дүн	6
1.2 Үндэслэл.....	11
1.3 Хөтөлбөрийн хамрах хүрээ, зарчим.....	13
ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ	15
2.1 Хөтөлбөрийн ерөнхий зорилго	15
2.2 Хөтөлбөрийн зорилго, зорилтууд	15
ГУРАВДУГААР БҮЛЭГ. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	19
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХӨТӨЛБӨРИЙН ҮР НӨЛӨӨ, БҮТЭЭГДЭХҮҮН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	31
ТАВДУГААР БҮЛЭГ. ТӨСӨВ, САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР	35
ЗУРГАДУГААР БҮЛЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	36
6.1 Хяналт шинжилгээ, үнэлгээ хийх байгууллага, нэгтгэн тайлагнах хугацаа	36
6.2 Хяналт шинжилгээ, үнэлгээний үр дүн, санал зөвлөмжийг хэрэгжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагаа.....	36
1. ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮДИЙН УЯЛДАА	Error! Bookmark not defined.
2. САНХҮҮЖИЛТ, САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭРИЙН ТООЦОО (сая төг).....	Error! Bookmark not defined.
4. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН НӨЛӨӨЛЛИЙН УРЬДЧИЛСАН ҮНЭЛГЭЭ	Error! Bookmark not defined.
5. ХБХ-ИЙН ЭРХИЙГ ХАНГАХ, ОРОЛЦОО, ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХҮСНЭГТ	Error! Bookmark not defined.
6. АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	Error! Bookmark not defined.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АХБ	Азийн хөгжлийн банк
АТҮГ	Авто тээврийн үндэсний газар
АЭМГ	Аймгийн эрүүл мэндийн газар
БСШУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
БТСГ	Биеийн тамир спортын газар
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗГ	Засгийн газар
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗТХЯ	Зам, тээврийн хөгжлийн яам
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МБСБ	Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага
МПХ	Монголын паралимпийн холбоо
МҮОНТ	Монголын үндэсний олон нийтийн телевиз
МҮОНРТ	Монголын үндэсний олон нийтийн радио телевиз
МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
МТХ	Монголын телевизүүдийн холбоо
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
НЭМГ	Нийслэлийн эрүүл мэндийн газар
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын тамгын газар
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ОУБ	Олон улсын байгууллага
ОУХБ	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
СЗСҮТ	Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төв
СХЗГ	Стандартчилал, хэмжил зүйн газар
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
СЯ	Сангийн яам
ТББ	Төрийн бус байгууллага
УАШТ	Улсын аварга шалгаруулах тэмцээн
ОӨУБЕГ	Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар

УИХ	Улсын Их Хурал
ҮШБ	Үндэсний шигшээ баг
ХБХЭТ НҮБК	“Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай” НҮБ-ын конвенци
ХХМТГ	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХБ	Хөгжлийн бэрхшээл
ХБ хүүхэд	Хөгжлийн бэрхшээлтэй 0-16 насны хүүхэд
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд (зөвхөн 16-аас дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс)
ХБХ	Хөгжлийн бэрхшээлтэй хүн (хүүхэд, насанд хүрэгсэд бүгдийг хамруулж ойлгоно)
ХБХЭХК	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХХЗХ	Харилцаа холбооны зохицуулах хороо
ХЭҮК	Хүний эрхийн үндэсний комисс
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ЭМХТ	Эрүүл мэндийн хөгжлийн төв
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭХЭМҮТ	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв

**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХ, ОРОЛЦООГ
НЭМЭГДҮҮЛЭХ, ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР
(2017-2021)**

УДИРТГАЛ

Монгол Улс “Тогтвортой хөгжлийн 17 зорилго”-ыг хэрэгжүүлэхийн тулд “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”-ыг 2016-2030 онд хэрэгжүүлэхээр боловсруулсан. Мөн төрөөс Хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого (2016-2025)-ыг 2016 онд баталсан.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн “Нийгмийн бодлого” буюу гуравдугаар бүлгийн 3.3-т Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, нийгмийн хамгааллыг сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг дараах байдлаар дурдсан. Үүнд 3.3.28. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн амьдралд хэвийн оролцох боломжийг бүрдүүлэх бодлого баримтална; 3.3.29. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг үеийн найзуудтайгаа хамт суралцах нөхцөлийг бүрдүүлж, шаардлагатай дэд бүтцийг сайжруулна; 3.3.30. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сурах, хөгжих үйлчилгээ үзүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангасан аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлнэ гэж заасан.

2016 оны 2-р сарын 5-нд Монгол Улсын Их хурлаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль” батлагдсанаар Монгол Улс Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын Конвенцийн зарчимд нийцсэн хуультай болсон.

Энэхүү Конвенцийг Монгол Улс 2009 онд нэмэлт протоколын хамт соёрхон баталсан бөгөөд 2011 онд анхны тайлан илтгэлээ НҮБ-ын ХБХ-ний эрхийн хороонд илгээж, Хороо Монгол Улсын анхны илтгэлийг (CRPD/C/MNG/1) 2015 оны 4 дүгээр сарын 8, 9-нд 188, 189-р уулзалтаараа (CRPD/C/SR.188 and 189) авч хэлэлцэн, 2015 оны 4 дүгээр сарын 16-ны 199-р уулзалтаар (CRPD/C/SR.199) дүгнэж, 2015 оны 5 дугаар сарын 13-нд Монгол Улсын Засгийн газарт дүгнэлт зөвлөмжөө хүргүүлсэн.

Конвенцийг хэрэгжүүлэх арга зам нь Хамт олонд түшиглэн хамруулах хөгжүүлэх стратеги бөгөөд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль энэхүү үзэл баримтлал дээр үндэслэсэн юм.

Ази, Номхон далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хөгжүүлэх 2013-2022 оны “Эрхийг бодит болгоё” стратеги буюу Инчеоны стратегийг Монгол Улсын Засгийн газар хэрэгжүүлж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах, оролцоог нэмэгдүүлэх, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр нь Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, холбогдох журам, стандарт, хөгжлийн бэрхшээлийн олон улсын хууль, дүрмүүдийг хэрэгжүүлэх Засгийн газрын дунд хугацаа (2017-2021)-ны хөгжлийн бодлогын баримт бичиг юм.

Энэхүү бодлогын баримт бичгийг Монгол Улсын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль болон түүнийг боловсруулах нийтлэг журам /2016 оны 249 дүгээр тогтоолын хавсралт/-ын дагуу боловсруулсан. Үндэсний хөтөлбөр нь салбар дундын хамтын ажиллагааг хангаж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоог хангаж, тэднийг хөгжих боломжийг олгох юм.

Хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн өнөөгийн нөхцөл байдал, тулгарч буй бэрхшээлүүдийн талаарх судалгааг багтаан стратегийн чухал хэсэг болох дунд хугацааны зорилго, зорилтууд, үр дүн, шалгуур үзүүлэлтүүд болон үйл ажиллагааны хэрэгжилтийн үе шатыг тодорхойлсон.

Мөн Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бусдын нэгэн адил идэвхтэй иргэн болгон төлөвшүүлэхтэй холбогдон гарч буй бусад олон улсын баримт бичгүүд, тухайлбал Тогтвортой хөгжлийн зорилт, Ази номхон далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан “Эрхийг бодит болгоё” 2013-2022 оны Инчеоны стратеги, ДЭМБ, ОУХБ, ЮНЕСКО, АидиДиСи байгууллагуудын хамтран боловсруулсан Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамт олонд түшиглэн сэргээн засах удирдамж, ДЭМБ-ын Хөгжлийн бэрхшээлийн талаарх үйл ажиллагааны төлөвлөгөө 2014-2021, Сэргээн засалт 2030 зэрэг баримт бичгүүдийг улсын хэмжээнд хэрэгжүүлэхэд энэхүү үндэсний хөтөлбөр хувь нэмрээ оруулах юм.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1 Тулгамдаж байгаа асуудал, нөхцөл байдлын дүн шинжилгээний гол үр дүн

Монгол улсад албан ёсоор хоёр удаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийсэн.

2004 онд Үндэсний статистикийн газарт Азийн Хөгжлийн Банкны техникийн тусламжтайгаар хэрэгжсэн “Монгол улсын нийгмийн статистикийг боловсронгуй болгох” төслийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх статистик мэдээллийг сайжруулах, үзүүлэлтийн тогтолцоо, аргачлалыг олон улсын жишигт нийцүүлэх зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нэг удаагийн бүртгэл, түүвэр судалгааг явуулсан.

Хүн амын мэдээллийн хамгийн бодитой эх үүсвэрийн нэг болох “Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллого”-оор хөгжлийн бэрхшээлтэй иргэний талаар холбогдох мэдээллийг гаргасан. Үүний дүгнэлт, зөвлөмжийг дурдахад¹:

ДҮГНЭЛТ

Монгол Улсад бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогийн улмаас жирийн иргэдийн адил нийгмийн харилцаанд орох боломж нь бүрмөсөн болон түр хязгаарлагдсан 108 071 иргэн байгаа нь суурин хүн амын 4.1 хувийг эзэлж байна. Хөгжлийн бэрхшээлтэй 3 хүн тутмын нэг нь төрөлхийн, 2 нь олдмол хөгжлийн бэрхшээлтэй иргэн байгаа нь манай улсын хүн амын дунд өвчлөл, гадны шалтгаант эмгэг согог, осол гэмтлийн улмаас хөгжлийн бэрхшээлд өртөх эрсдэл илүү байгааг харуулж байна. Үүнтэй холбоотойгоор хөгжлийн бэрхшээлийн илрэх хэлбэрээс түгээмэл нь хөдөлгөөний хөгжлийн бэрхшээл байв. Иймээс цаашид олдмол хөгжлийн бэрхшээлийн шалтгааныг нарийвчлан судалсны үндсэн дээр түүнээс урьдчилан сэргийлэх, улмаар хөгжлийн бэрхшээлийн тохиолдлыг бууруулах боломж байгаа нь харагдаж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй эрэгтэй хүн амын тоо эмэгтэй хүн амын тооноос илүү байгаа хандлага 70 хүртэлх бүх насны бүлэг, хөгжлийн бэрхшээлийн төрөл, хэлбэрийн аль алинд ажиглагдаж байна. Төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй хүн амын хүйсийн харьцаа 136 байгаа нь эрүүл төрсөн хэдий ч амьдралын явцад хөгжлийн бэрхшээлд өртсөн байдал эрэгтэйчүүдийн дотор илүү байгааг илтгэнэ. Энэ нь нэг талаар хоол хүнс, архи, тамхины зохисгүй хэрэглээ, осол гэмтэлд өртөх эрсдэл эрэгтэйчүүдэд харьцангуй илүү тохиолдогттой холбоотой.

Төрөлхийн бэрхшээлийн тохиолдол залуу насны хүн амд түгээмэл байснаа хүн амын нас ахихын хэрээр олдмол бэрхшээлд өртсөн иргэдийн хувь өссөн явдал нь төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй хүн амын голч нас харьцангуй залуу, харин олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүн амын голч нас хөгшин гарахад нөлөөлсөн. Эхээс хөгжлийн бэрхшээлтэй төрсөн, тооллогын үед амьд байсан хүн амын ½ нь 30 хүртэлх, ½ нь түүнээс дээш насныхан байв. Харин олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүн амын голч нас үүнээс 16 жилээр урт байна.

Хөгжлийн бэрхшээлтэй 10 хүүхэд тутмын 6-7 нь ерөнхий боловсролын сургуульд элсэн орж, 4-р анги хүртлээ суралцаж байгаад дунд ангид ороход тэдний 1-2 нь, ахлах ангид мөн л 1-2 нь сургуулиас завсардсанаар тэд бага, суурь цаашлаад

¹ Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллого: Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, сэдэвчилсэн судалгаа, Монгол улсын Үндэсний Статистикийн хороо, 2011 он, Улаанбаатар хот

бүрэн дунд боловсролыг эзэмшиж чадахгүй хүрч байна. Эдгээр хүүхдүүд нас ахих тутам сургуульд суралцах нь багасаж байгаа нь ичиж зовох, нийгмийн амьдралд чөлөөтэй оролцохоос айж эмээх гэх мэт шалтгаантай холбоотой байж болох тул үүнийг цаашид гүнзгийрүүлэн судлах бодит хэрэгцээ байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд сургуульд суралцах хүсэл, эрмэлзэл байвч манай улсад эдгээр иргэд саадгүй чөлөөтэй зорчих гудамж талбай, зам, нийтийн тээвэр, барилга байгууламж, сургалтын материаллаг орчин хангалтгүй байгаа явдал нь тэдний суралцах эрхийг хязгаарлаж, нийгэмд боловсролгүй, “үл үзэгдэгч” байдлаар амьдрах нөхцлийг бүрдүүлсээр байна.

Эдийн засгийн идэвхгүй хөгжлийн бэрхшээлтэй хүн амд хөдөлмөр эрхлэх чадваргүй гэсэн шалтгаан зонхилсон нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд бие махбод, оюун ухаан, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн эмгэгийн улмаас нийгмийн амьдралд оролцох боломжоор хязгаарлагдаж байгаагийн бодит илрэл болж байна. Мөн ажил эрхэлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүн амд хувиараа хөдөлмөр эрхлэх, өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцох байдал өндөр, эсрэгээр цалин хөлстэй ажиллах байдал доогуур байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрлөх орчин, нийгэм сэтгэл зүйн уур амьсгал бүрдээгүй болохыг харуулж байна.

Арван тав, түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хүн амын талаас илүү хувь нь гэр бүлтэй байгаа нь төдийлөн доогуурт тооцогдох үзүүлэлт биш юм. Хөгжлийн бэрхшээлийн тохиолдол нийт өрхийн дунд ямар байгааг авч үзвэл 13 өрх тутмын нэг нь хөгжлийн бэрхшээлтэй нэг, түүнээс дээш тооны хүн амьдарч байгаа ба тэдгээр өрхүүдийн ус, цахилгаан, халаалт зэрэг ахуйн нөхцлийн үзүүлэлт нь улсын дунджаас доогуур анхаарал татсан түвшинд байна. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд нийгмийн амьдралд оролцох боломжоор хязгаарлагдмал аж төрөхийн зэрэгцээ цахилгаан, дулаан, халуун усны хангамж, бие засах газар, хог хаягдал зайлуулалт гэх мэт дэд байгууламжийн хувьд шаардлага хангахгүй нөхцөлд амьдарч буй байдал илүүтэй байгааг харуулж байна.

ЗӨВЛӨМЖ

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх статистик мэдээллийг сайжруулах хүрээнд:

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нөхцөл байдлыг бодитойгоор үнэлж дүгнэж, шаардлагатай бодлого, арга хэмжээг оновчтой төлөвлөхийн тулд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх бүртгэл, мэдээллийг сайжруулах, статистик мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байршил, төрөлт, нас баралт, дундаж наслалт, ажил эрхлэлт, боловсролын үйлчилгээнд хамрагдалт зэрэг хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдээр гаргаж, олон нийтэд хүртээмжтэй болгох;

Дэлхий дахинаа хөгжлийн бэрхшээлийг нийгэм, эдийн засаг, соёл, хүний эрхийн талаас авч үзэж буй өнөө үед хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн аж байдал, амьдралын хэв маяг, эрхээ эдэлж буй байдал, ялгаварлан гадуурхалтанд өртөх эрсдэл, итгэл үнэмшил зэргийг тодруулсан суурь болон хавсарга, цаашлаад мониторингийн судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг бодлогын түвшинд хөхүүлэн дэмжих;

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлаар үндэсний болон аймаг, орон нутгийн түвшинд нэгдсэн мэдээллийн сүлжээ бий болгох, түүнд тогтмол шинэчлэл хийж, мэдээллийн чанар, найдвартай байдал, аюулгүй байдлыг ханган ажиллах,

хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлаар нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлэх, цахим хуудас нээж ажиллуулах;

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлаар түншлэл, хамтын ажиллагааг өргөжүүлэх хүрээнд:

Монгол Улс нь НҮБ-ын “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай” конвенцэд нэгдэн орсон орны хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах, тэднийг нийгэмшүүлэх, нийгмийн амьдралд оролцох боломжийг дээшлүүлэх бүхий л үйл ажиллагаанд оролцогч талын түншлэл, хамтын ажиллагааг өргөжүүлэх;

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тухай хууль тогтоомж, бодлогыг хэрэгжүүлэх, хэрэгжилтэнд нь хяналт тавих, энэ хүрээнд ажиллаж буй төрийн, төрийн бус болон олон улсын байгууллагын үйл ажиллагааг үнэлж дүгнэхэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл, тэдний эрх ашгийг хамгаалан ажилладаг төрийн бус байгууллагыг өргөнөөр оролцуулах;

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийг сайжруулах хүрээнд:

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сурч боловсрох, ажил хөдөлмөр эрхлэх, нийгмийн амьдралд оролцох боломжийг дээшлүүлэхийн тулд тэдэнд зориулсан дэд бүтцийг сайжруулахад онцгой анхаарах, энэ чиглэлийн үйлдвэрлэгчдийг дэмжих, тэдэнд зориулсан татвар, зээл, санхүүгийн бусад хөшүүрэг бий болгох;

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийг сайжруулах чиглэлээр, нийгмийн хариуцлагынхаа хүрээнд бүтээн байгуулалтын ажил санаачлан хэрэгжүүлсэн байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах, бусад дэмжлэгийн механизмыг бий болгох;

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсролын үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэх хүрээнд:

Сургууль, цэцэрлэгийн орчныг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ээлтэй хэлбэрээр засч тохижуулах, сургалтын бааз, хэрэглэгдэхүүнээр хангах ажлыг бодлогын түвшинд зохион байгуулж хэрэгжүүлэх;

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн сургууль, цэцэрлэгт сурч хүмүүжихэд зориулсан сургалтын тусгай хөтөлбөр боловсруулах, шаардлагатай сургалтын материал, хэрэглэгдэхүүнийг бэлтгэж, хэрэгжүүлэх;

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд багшлах боловсон хүчний чадварыг дээшлүүлэх, тэдний хөдөлмөрийн нөхцөл, цалин, урамшууллыг боловсронгуй болгох, тогтвор суурьшилтай ажиллах нөхцлийг бүрдүүлэхэд онцгой анхаарах;

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хүрээнд:

Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх, тодруулбал хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангах, дадлагажуулах, ур чадварыг нь дээшлүүлэх, ажлын цагийг хөнгөлөх, нийгмийн асуудлаа шийдвэрлэхэд нь дэмжлэг үзүүлэх зэрэг асуудлыг хамтын болон хөдөлмөрийн гэрээндээ тусган хэрэгжүүлэх;

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд хөдөлмөрөө хоршин ажиллах, амьжиргаагаа дээшлүүлэхэд чиглэсэн олон нийтийн оролцоонд тулгуурласан санаачлага, төслийг бүх талаар дэмжих;

зэрэг болно.

Дээрх дүгнэлт, зөвлөмж дээр үндэслэн дараах асуудлуудыг энэхүү үндэсний хөтөлбөрт хамруулан авч үзэж байна:

- 1. Эрүүл мэнд** - 2015 оны байдлаар нийт 1.671.913 хүн сэргээн засалтын үйлчилгээг авсан. Үүнээс 801.779 нь эмэгтэй байна. Нийт 2989 хүн протез хийлгэсэн. Байнгын асаргаанд 16.338 хүн байна². Одоогийн байдлаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст сэргээн засах үйлчилгээ үзүүлж буй талаар статистик мэдээлэл байхгүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулж эрүүл мэндийг дэмжих ажиллагаа явуулах, хөгжлийн бэрхшээлээс урьдчилан сэргийлэх талаар үйл ажиллагаа дутмаг байна.
- 2. Боловсрол** - 2016-2017 оны хичээлийн жилийн статистик мэдээгээр Монгол улсын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 1513 хүүхэд сургуулийн өмнөх боловсролын байгууллагад, 8362 хүүхэд ерөнхий боловсролын сургуульд суралцаж байна. Үндэсний хэмжээнд 6 тусгай сургууль байгаагаас харааны бэрхшээлтэй хүүхдийн 1, сонсголын бэрхшээлтэй хүүхдийн 1, оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 4 тусгай сургуульд нийт 1621 хүүхэд суралцаж байна³. Судалгаагаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн 40 орчим хувь нь цэцэрлэг, сургуулийн бага ангид суралцаж байдаг бол энэ хувь буурсаар дунд, ахлах анги, цаашлаад их дээд сургуульд суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо, хувь нас ахих тутам буурсаар байгаа нь БСШУСЯ-ны албан ёсны статистик мэдээнээс харагдаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй боловсролгүй иргэдийн хувь 19.8 байгаа нь нийт хүн ам дахь ийм иргэдээс (4.8 хувь) даруй 4 дахин өндөр байна⁴. 2010 оны ЮНИСЕФ-ийн судалгаагаар 6-19 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудын дөнгөж 44.4 хувь нь л боловсролд хамрагдсан гэсэн тоо гарчээ⁵.
- 3. Хөдөлмөр эрхлэлт** - Хөгжлийн бэрхшээлтэй хүн хөдөлмөрийн зах зээлд оролцох боломж хангалтгүй, тэдгээрийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төрийн бодлого дутагдаж байна. Хөдөлмөрийн тухай хуульд заасан 25, түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж байгууллага нь ажил, албан тушаалынхаа дөрөв, түүнээс дээш хувийн орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй болон одой хүнийг ажиллуулах хуулийн заалтыг биелүүлээгүй тохиолдолд ноогдох торгуулийн хэмжээ хэт бага байгаагаас хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд нөлөө үзүүлж чадахгүй байна. Тэднийг дэмжсэн нийгмийн хариуцлагын бодлогыг боловсруулж, хэрэгжилтийг хангах шаардлага зүй ёсоор тулгарч байна. ҮСХ-ны 2015 оны тайланд дурдсанаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ажил эрхлэлт дөнгөж 19.37 хувьтай байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн аж ахуй эрхлэх, бизнесийн үйл ажиллагаа явуулахыг дэмжсэн шинэ бодлого боловсруулах шаардлага гарч байна.

² Эрүүл мэндийн үзүүлэлт 2015. Улаанбаатар хот

³ 2016-2017 оны хичээлийн жилийн статистик мэдээ, БСШУЯ

⁴ Монгол Улсын Нийгмийн халамжийн хөтөлбөрүүд: Үр шимийг хүртэгчдийн байдалд хийсэн дүн шинжилгээ. Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, Дэлхийн банк, 2015

⁵ Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал – 2030: Үндэслэл, хамрах хүрээ. Монгол улсын Их хурал, 2016 он, Улаанбаатар хот

- 4. Нийгмийн хамгааллын бодлого** - Өнөөгийн нийгмийн хамгааллын бодлогын тогтолцоо нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээг хангаж чадахгүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээг тодорхойлох тогтолцоо, олон нийтийн оролцоонд түшиглэсэн үйлчилгээний төрлүүдийг хөгжүүлэх шаардлагатай байна. Энэхүү хөтөлбөр нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бие даан амьдрах, сонголт хийх болон нийгмийн харилцаанд ямарваа нэг ялгаварлан гадуурхалтад өртөхгүйгээр бусдын адил тэгш оролцох эрхийг хамгаалах тухай Монгол Улсын Засгийн газрын бодлогын нэг чухал хэсэг юм. Энэхүү баримт бичгийг Засгийн газар болон түүний хэрэгжүүлэгч агентлагууд, орон нутгийн засаг захиргааны нэгжүүд болон төрийн бус байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудлаар аливаа шийдвэр гаргах, үйл ажиллагаагаа явуулахдаа удирдамж болгоно. АХБ, Дэлхийн банкнаас өгсөн мэдээллийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан нийгмийн халамжийн тэтгэвэр авагчдаас буюу 34,402 хүний 18% орчим (6065 хүн) нь хөгжлийн бэрхшээлгүй иргэд байна. Энэ нь одоогийн нийгмийн халамжийн төлбөр тооцооны системийн үр ашгийг сайжруулах зорилгоор аудит хийх шаардлагатайг харуулж байна.
- 5. Хүртээмж** - Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдрах орчин, дэд бүтцийг тэдний хэрэгцээ шаардлагад нийцүүлэх, мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээг хүртээмжтэй болгох тухай тусгаж, дохионы хэл болон брайл үсгийн стандартын тухай зохицуулалтыг оруулсан. Гэвч харилцаа холбооны хялбаршуулсан “easy-to read/уншихад хялбар” хэлбэрүүд болон оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан харилцааны туслах технологийн талаарх зохицуулалт байхгүй хэвээр байна. Холбогдох хуулиудад (боловсрол, нийгмийн халамж, эрүүл мэнд, барилга байгууламж, зам тээвэр, төрийн үйлчилгээ, захиргааны журмууд, харилцаа холбооны технологи) хүртээмжийн тухай хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд заасны дагуу нэмэлт, өөрчлөлт оруулах, мөн хүртээмжийн стандарт, тухайн хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд хариуцлага тооцох тухай заалтыг тусгаж өгөх, хуулийн хэрэгжилтийг хангах, хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог бий болгох шаардлага гарч байна. Төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжүүд, хувь хүн аливаа үйлчилгээ, бараа бүтээгдэхүүнийг худалдан борлуулахдаа бүх нийтэд хүртээмжтэй орчинг бүрдүүлэх үүргийг хуульчлах ёстой. Нийтийн тээвэр, зам, барилга, орон сууц, олон нийтийн барилга байгууламж, мэдээллийн хүртээмжгүй байдал, эрх зүйн зохицуулалт дутмагаас болоод хөгжлийн бэрхшээлтэй хүн нийгмийн харилцаанд бусдын адил оролцох боломжгүй байна.
- 6. Мэдээллийн сан** - Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх статистикийн мэдээлэл хангалтгүй, мэдээллийн сан байхгүй байна. Зөвхөн онцгойлсон тохиолдолд хөгжлийн бэрхшээлийн талаар судалгаа авч байна. Тухайлбал Үндэсний статистикийн газраас 2004 онд нэг удаагийн түүвэр, 2010 онд Хүн амын орон сууцны тооллогын үед сэдэвчилсэн судалгаа авсан байна. Эрүүл мэндийн статистик үзүүлэлт дээр Хамт олонд түшиглэн сэргээн засах хөтөлбөрийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тоо жил бүр гарч байна. Гэхдээ энэ нь учир дутагдалтай, хангалтгүй байна.
- 7. Ялгаварлан гадуурхалт** - Хөгжлийн бэрхшээлтэй хүн нь ялгаварлан гадуурхалттай өдөр тутам тулгарч байна. Хэдийгээр хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд ялгаварлан гадуурхалтыг халах тухай заасан ч,

холбогдох салбарын хуулиудад, хөдөлмөр эрхлэлт, боловсрол, эрүүл мэнд, төрийн үйлчилгээ зэрэг чиглэлүүдээр мөн тусгаж өгөх шаардлагатай байна. Түүнээс гадна хуулийн биелэлтийг хангаж байгаа эсэхийг үнэлэх хяналтын систем, хуулийг биелүүлээгүй тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах, эрх нь зөрчигдсөн хүмүүст нөхөн олговор олгох тухай хуулийн зүйл заалт байхгүй хэвээр байна. Сургуулийн өмнөх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд ерөнхий боловсролын сургуульд хамрагдан суралцах боломжийг нь нэмэгдүүлэх зорилго бүхий сургалтын хэлбэрүүдийг нэвтрүүлэх, мөн мэргэжлийн боловсролын болон чадамж эзэмшүүлэх сургалтуудад хамрагдах эрхийг хуульчлах шаардлагатай.

- 8. Олон нийтийн мэдлэг ойлголт** - Хүний эрхийн талаас биш хөгжлийн бэрхшээлийг эмнэлгийн загварын дагуу оношлох, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг гутаан доромжлох, хөгжлийн бэрхшээлийг сөрөг үзэгдэл мэт авч үзэх нийгмийн хандлага байсан хэвээр байна. Хөгжлийн бэрхшээлийг ихэнх тохиолдолд хөдөлгөөний болон мэдрэх чадамж дээр үндэслэн тодорхойлж, хөгжлийн бэрхшээлтэй хүний оюуны болон сэтгэл зүйн чадамжийн асуудлыг орхигдуулж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх ойлголт, мэдлэг нийгмийн аль ч түвшинд хангалтгүй, эдгээр хүмүүсийн асуудалд хүний эрхийн бус халамж, эмнэлгийн загвар талаас ханддаг, мөн хөгжлийн бэрхшээлтэй хүнд хандах сөрөг хандлага байсаар байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд хөгжлийн бэрхшээлийг биеийн үйлийн олон улсын ангилал (ICF)-аар тодорхойлох тухай тусгасан боловч үүнийг дагалдаж холбогдох хууль, дүрэм журамд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай.
- 9. Эрх зүйн чадамж** - Өнөөгийн хууль тогтоомж нь оюуны бэрхшээлтэй хүмүүсийн эрх зүйн чадамжийг хязгаарлахыг зөвшөөрч, улмаар энэ нь оюуны болон сэтгэлзүйн хөгжлийн бэрхшээлтэй хүн бие даан шийдвэр гаргах эрх болон бусад эрхээ эдлэх эрхийг нь хязгаарлаж байна. Үүнд эмчилгээг хүлээн зөвшөөрөх болон эмчилгээнээс татгалзах, шүүхийн байгууллагаар үйлчлүүлэх, гэрлэх, ажил эрхлэх, хэнтэй, хаана амьдрах тухай шийдвэр гаргах, эцэг, эхийн эрхээ эдлэх, бие даан амьдрах, нийгэмд тэгш оролцох, өөрийн санхүү, хөрөнгийн тухай шийдвэр гаргах зэрэг асуудлууд багтана. Эрх шилжүүлэх тухай хуулийн зохицуулалт нь оюуны болон сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүний асран хамгаалагчдын шийдвэрээр албадан эмчилгээнд хамруулах, нийгмээс тусгаарлах, ингэснээр ямарваа нэг хүчирхийлэлд өртөх нөхцөлийг бүрдүүлж байна.
- 10. Шийдвэр гаргах түвшний оролцоо** - Үндэсний болон орон нутгийн түвшинд аливаа улс төрийн бодлого болон хууль эрх зүйг боловсруулах явцад хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй зөвшилцөх тухай хууль зүйн аливаа зохицуулалт байхгүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүн улс төрийн шийдвэр гаргахад оролцох, сонгох, сонгогдох эрхээ хэрэгжүүлэх талаарх эрх зүйн зохицуулалтыг бий болгох шаардлагатай.
- 11. Гамшгийн менежмент** - Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байршил, амьдарч буй газар нутгийн талаарх мэдээллийн сан, мөн гамшгийн нөхцөлд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст үзүүлэх шаардлагатай туслалцааны талаарх зохицуулалт, механизм байхгүй байна.

1.2 Үндэслэл

Манай улс хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмийн харилцаанд аливаа ялгаваргүйгээр тэгш оролцуулах нөхцлийг бүрдүүлэх, тэдний өвөрмөц хэрэгцээнд түшиглэсэн нийгмийн хамгааллын үйлчилгээ үзүүлэх зорилгоор 1995 онд Хөгжлийн

бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийг баталж, уг хуулиар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст үзүүлэх нийгмийн хамгааллын арга хэмжээ, тэдэнд үзүүлэх тусламж, хөнгөлөлт олгох хууль эрх зүйн суурийг бий болгосон. 2009 онд Монгол Улс Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийг соёрхон баталснаас хойш хууль эрх зүйн орчин конвенцийн үндсэн зарчимд нийцэхгүй, тэднийг зөвхөн халамж, хамгаалал хүртэгч, нийгмийн идэвхгүй гишүүн мэтээр хардаг байв.

2016 оны 2 дугаар сард шинэчлэн баталсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль дээрх нөхцөл байдлыг эвдэж, нийгмийн идэвхтэй гишүүн болохын тулд үндсэн эрхээ эдэлж, эрхэм зэргийг хүндэтгэсэн, хөгжих боломж олгосон хууль болсон бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүнд нэн тэргүүнд тулгамдаж байгаа асуудлууд болох нийтийн тээвэр, зам, орон сууц, олон нийтийн барилга байгууламжийг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй, хэрэгцээ, шаардлагыг нь хангасан байдлаар төлөвлөж, барьж байгуулах, тэдний ажиллаж, амьдрах орчин, нөхцлийг нь сайжруулах арга хэмжээг хуульчлан заасан болно.

Түүнчлэн боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, нийгэм-сэтгэл зүйн хэрэгцээт үйлчилгээг авах, бусдын нэгэн адил амьдрах тэгш эрхийг хүлээн зөвшөөрч, энэхүү эрхээ эдлэх явдлыг хангах, нийгмийн харилцаанд бүрэн хамрагдах, оролцохыг дэмжих, соёл урлаг, спортын арга хэмжээнд тэгш хамруулах, авьяас чадварыг нь нээн хөгжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүнд урлаг, соёлын бүтээл хүртээмжтэй байх асуудлыг боловсронгуй болгох зохицуулалтыг мөн тусгасан болно.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг оношлох, бүртгэх, сэргээн засах үйл ажиллагааг хуульд тодорхой заагаагүйгээс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нэгдсэн тоо байхгүй, Үндэсний статистикийн хороо болон холбогдох төрийн захиргааны төв байгууллагуудын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар гаргасан статистик мэдээллүүд хоорондоо зөрөөтэй байдаг.

2008 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийг Монгол Улсын Их Хурлаас соёрхон баталсан нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст эрхээ бусдын адил эдэлж нийгмийн харилцаанд орох боломжийг бүрдүүлсэн томоохон баримт бичиг болсон юм. Монгол Улс Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенци болон түүний нэмэлт протоколд 2008 онд нэгдэх тухай хүсэлтээ гаргаж, 2009 онд нэгдэн орсон. Нэмэлт протоколд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах хувь хүн болон байгууллагаас конвенцийн гишүүн улс болох Монгол Улсын эсрэг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх зөрчигдсөн тухай гомдол хүлээн авч болох тухай заасан байдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн 33-р зүйлийг хэрэгжүүлж, Монгол Улсын Засгийн газраас Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны бүтцэд хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн анхдагч нэгж байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар авах арга хэмжээг эрчимжүүлэх, төр, төрийн бус байгууллагуудын түншлэл, хамтын ажиллагааг шинэ шатанд гаргах, Засгийн газраас хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн чиглэлээр бодлого, хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэхэд томоохон дэвшил болсон.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгасан зорилтууд, салбар дундын болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын уялдаа холбоог ханган, олон улсын байгууллагуудын санхүүгийн дэмжлэгтэйгээр хамтран ажиллаж ирлээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийг хэрэгжүүлэх 2013-2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг Монгол Улсын

Засгийн газрын 2013 оны 8 дугаар сарын 02-ны өдрийн 281 тоот тогтоолоор баталсан.

Энэхүү төлөвлөгөө батлагдсанаар Монгол Улс Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийг системчлэн хэрэгжүүлэх, хэрэгжилтэнд нь дүн шинжилгээ, үнэлгээ хийх нөхцөл бүрдсэн юм.

Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тулгарч буй нийгэм, хүрээлэн буй орчны сорилт, ялгаварлан гадуурхах, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх нийгмийн хандлагыг өөрчлөх үйл ажиллагааг тусгасан.

Хот хөдөөгийн хөгжлийн ялгаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдрал, ахуйд сөргөөр нөлөөлж, нийгмийн хамгааллын үйлчилгээ, боловсрол, эрүүл мэнд, халамжийн үйлчилгээ тэгш хүртэх, хөдөлмөр эрхлэх, бие даан амьдрах зэрэг эрх нь зөрчигдөж, ялгаварлан гадуурхагдаж байна.

Монгол Улсын Засгийн газар 2011 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийн хэрэгжилтийн тухай анхны тайлангаа Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хороонд хүргүүлсэн ба 2015 оны 4 дүгээр сард Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийн тайланг хүлээн авч, 2015 оны 4 дүгээр сарын 16-ны 199 дүгээр уулзалтаар дүгнэлтээ гаргасан. Дүгнэлтэд Монгол Улс Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийн ерөнхий зарчмууд болон конвенцийн хүрээнд хүлээсэн үүргүүдээ хууль эрх зүй, бодлогодоо тусгах шаардлагатай талаар дурдсан.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг боловсруулах үйл явцад хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагуудын оролцоог хангаж өгсөн нь тэдний хэрэгцээг тусгах боломжийг бүрдүүлсэн. Энэхүү хууль нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах, баталгаажуулах, хэрэгжүүлэх тухай харилцааг зохицуулсан бөгөөд энэ нь НҮБ-ын конвенцийн зарчимд нийцсэн бусад хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүдийг боловсруулах суурь болж байгаа юм.

Хуулийг хэрэгжүүлэхийн тулд холбогдох дүрэм, журам, стандарт боловсруулан асуудлыг цогцоор шийдэхэд үндэсний хэмжээний хөтөлбөрийг боловсруулах зайлшгүй шаардлага гарсан.

Үндэсний хөтөлбөрөөр дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст нийгмийн бүх төрлийн харилцаанд бүрэн оролцох нөхцлийг бүрдүүлэх, хөгжлийн бэрхшээлийн талаар эерэг ойлголт, хандлагыг нийгэмд төлөвшүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй болохоос урьдчилан сэргийлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгмийн амьдралд оролцуулах, дуу хоолойг нь олон нийт, шийдвэр гаргах түвшинд хүргэх шаардлага, хэрэгцээ зайлшгүй бий болж байна.

1.3 Хөтөлбөрийн хамрах хүрээ, зарчим

Үндэсний хөтөлбөр нь Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал – 2030, Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого (2016-2025), Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, мөн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулна.

Хөтөлбөр нь дараах 8 зорилгын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалж, оролцоог нэмэгдүүлж, хөгжлийг дэмжих юм:

Зорилго 1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрүүл мэндийг боломжит дээд хэмжээнд нь хүргэх

Зорилго 2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг бүх шатны боловсролд тэгш хамруулах

Зорилго 3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг сайжруулах

Зорилго 4. Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах

Зорилго 5. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст саадгүй орчин, нийтийн тээвэр, мэдлэг, мэдээлэл, харилцааны хүртээмжийг сайжруулах

Зорилго 6. Хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх харьцуулж болохуйц, үнэн бодит тоон мэдээллийг бий болгох

Зорилго 7. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг эрх мэдэлжүүлэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх, эрхээ бусдын адил эдлэх, шийдвэр гаргах түвшин дэх болон улс төрийн оролцоог нэмэгдүүлэх, мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх

Зорилго 8. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг гамшгийн болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг нь хангах нөхцлийг бүрдүүлэх

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим

- Ялгаатай байдлыг хүндэтгэсэн, хөгжлийг дэмжсэн, хүртээмжтэй, сонголттой байх;
- Төрийн болон төрийн бус, олон улсын байгууллага, иргэдийн оролцоог дэмжин ил тод, нээлттэй, хяналттай байлгах;
- Тогтвортой, тасралтгүй, нээлттэй, залгамж холбоотой, техник технологийн дэвшил, практикт суурилсан байх;
- Иргэний нэр төр, алдар хүнд, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;
- Ялгаварлан гадуурхалтаас ангид хүн бүрийн эрх ашиг, эрүүл мэнд, ёс суртахуун, нийгмийн аюулгүй байдалд харшлахгүй байх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

2.1 Хөтөлбөрийн ерөнхий зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн талаар мэдлэг, ойлголтыг нийгмийн бүх түвшинд түгээх, төрийн болон орон нутгийн бодлого шийдвэрт Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудлыг тусгах, тэдэнд хүргэх үйлчилгээний тогтолцоог боловсронгуй болгох, салбар хоорондын уялдаа холбоог сайжруулах замаар хөгжлийн бэрхшээлтэй хүний амьдралын чанарт бодит өөрчлөлт оруулах.

Ерөнхий зорилгоо хангахын тулд үндэсний хөтөлбөр нь дараах 8 зорилгыг биелүүлэх шаардлагатай.

2.2 Хөтөлбөрийн зорилго, зорилтууд

Нэгдүгээр зорилго. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрүүл мэндийг боломжит дээд хэмжээнд хүргэх

Энэхүү зорилго нь Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хандсан, тэдний эрх ашгийг хамгаалахаар гарсан хууль, тогтоомж, Засгийн газрын мөрийн хөтөлбөр, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийн 25 дугаар зүйл заалтыг удирдлага болгон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулах үйл ажиллагааны хэрэгжилтэнд хяналт тавьж шаардлагатай эрх зүйн болон санхүүгийн хувьд дэмжсэн олон талт үйл ажиллагааг шат, шатандаа зохион байгуулах зайлшгүй шаардлагатай байна.

Зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтуудын хүрээнд арга хэмжээг авна. Үүнд:

Зорилт 1.1. Эрүүл мэндийг дэмжих

Зорилт 1.2. Хөгжлийн бэрхшээлтэй болохоос урьдчилан сэргийлэх

Зорилт 1.3. Эмнэлгийн тусламж үйлчилгээг хүний эрхэд суурилсан хандлагаар хүргэх

Зорилт 1.4. Туслах хэрэгслийн хүртээмжийг нэмэгдүүлэх

Зорилт 1.5. Чанартай сэргээн засалтын үйлчилгээ үзүүлэх

Зорилт 1.6. Хүртээмжтэй орчин бий болгох

Зорилт 1.7. Хөгжлийн бэрхшээлийн олон улсын ангиллыг нэвтрүүлэх

Зорилт 1.8. Эрүүл мэндийн бодлогын хүрээнд

Хоёрдугаар зорилго. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг бүх шатны боловсролд тэгш хамруулах

Хүний эрхэд суурилсан сурч боловсрох эрхийн талаарх төрийн зүгээс зайлшгүй хэрэгжүүлэх арга хэмжээний заалтад бүх нийтийн боловсрол эзэмших эрхийг хангахад чиглэсэн холбогдох хууль тогтоомжийг хянан үзэх, тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдийг боловсролын гадна үлдээхгүйгээр чанартай боловсролд тэгш хамруулахыг чухалчилна.

Зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтуудын хүрээнд арга хэмжээг авна. Үүнд:

Зорилт 2.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг боловсролын үйлчилгээнд хамрагдах нөхцөл боломжийг хангахад чиглэсэн эрх зүйн орчныг бүрдүүлэх

Зорилт 2.2. Сургуулийн өмнөх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бүрийг цэцэрлэгт хамруулах

Зорилт 2.3. Хүүхдийн хөгжлийн онцлог хэрэгцээнд нийцүүлэн бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх

Зорилт 2.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний мэргэжлийн болон дээд боловсрол эзэмших боломжийг нэмэгдүүлэх

Зорилт 2.5. Хөгжлийн бэрхшээлтэй хүн амьдрах ухааны болон мэргэжлийн чиг баримжаатай болоход нь дэмжлэг үзүүлэх насан туршийн боловсролын үйлчилгээний загварыг хөгжүүлэх

Зорилт 2.6. Хүртээмжтэй орчин бий болгох

Зорилт 2.7. ХБХ-ийг биеийн тамир, спорт, соёлын арга хэмжээнд татан оролцуулах, тэдний амьдралын зөв дадал хэвшилд сургах

Гуравдугаар зорилго. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг сайжруулах

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс цалин хөлстэй хөдөлмөр эрхэлж, өөртөө болон өрх гэр бүлдээ эдийн засгийн дэмжлэг үзүүлэх боломж харьцангуй бага байсаар байна. Үүнээс үүдээд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ядууралд өртөж, амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур аж төрж байна. Ажил эрхлэх хүсэл сонирхолтой, хөдөлмөрийн насны хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг төрөөс бодлогоор дэмжих нь ядуурлыг бууруулах хамгийн шилдэг арга зам болно.

Зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтуудын хүрээнд арга хэмжээг авна. Үүнд:

Зорилт 3.1. Ур чадварыг хөгжүүлэх

Зорилт 3.2. Хувиараа хөдөлмөр эрхлэх

Зорилт 3.3. Цалинтай хөдөлмөр эрхлэх

Зорилт 3.4. Санхүүгийн үйлчилгээ

Зорилт 3.5. Ажлын байрыг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй болгох, тохируулгатай ажлын байраар хангах

Зорилт 3.6. Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хүрээнд

Дөрөвдүгээр зорилго. Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах

Монгол Улсын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх төрийн бодлого нь голчлон нийгмийн халамжийн үйлчилгээгээр хязгаарлагдаж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст эмнэлгийн загвараар хандсан хэвээр байсаар байна. Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, хөгжлийн бэрхшээлийг тодорхойлох, тэдний хэрэгцээ шаардлагад тохирсон үйлчилгээ үзүүлэх тогтолцоо сул, хүртээмжгүй байна. Иймээс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусдын адил ижил тэгш байдлаар нийгмийн хамгааллын үйлчилгээг хүртэх байдлыг хангах нь чухал бөгөөд тухайн нийгэмд бие даан амьдрах боломжийг бий болгох шинэлэг үйлчилгээнүүд шаардлагатай байна.

Зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтуудын хүрээнд арга хэмжээг авна. Үүнд:

Зорилт 4.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бие даан амьдрахад чиглэгдсэн үйлчилгээг хөгжүүлэх

Зорилт 4.2. Хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээг сайжруулах

Зорилт 4.3. Нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд

Тавдугаар зорилт. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст саадгүй орчин, нийтийн тээвэр, мэдлэг, мэдээлэл, харилцааны хүртээмжийг сайжруулах

Хөгжлийн бэрхшээлтэй хүн бие даан амьдрах, тэднийг амьдралын бүх хүрээнд бүрэн оролцох боломжийг бий болгох, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бусдын нэгэн адил нийгмийн орчин, ялангуяа байшин барилга, байгууламж, зам тээвэр, мэдээлэл, харилцаа холбооны болон бусад төрлийн үйлчилгээ нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байхаар зохицуулагдсан байна.

Зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтуудын хүрээнд арга хэмжээг авна. Үүнд:

Зорилт 5.1. Барилга, зам, нийтийн тээврийн хүртээмжийг сайжруулах

Зорилт 5.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст мэдээллийн технологийн хүртээмжийг сайжруулах

Зургадугаар зорилго. Хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх харьцуулж болохуйц, үнэн бодит тоон мэдээллийг бий болгох

Хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх статистик тоо мэдээлэл үнэн зөв байх нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст чиглэсэн баримтад тулгуурласан бодлого боловсруулах боломжийг олгодог. Манай оронд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгэм-эдийн засгийн төлөв байдлын талаар илүү нарийн нэгдсэн тоо баримт шаардлагатай байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст чиглэсэн аливаа үйл ажиллагааг үр дүнтэйгээр хэрэгжүүлэхэд энэхүү мэдээллийн сан чухал ач холбогдолтой.

Зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтын хүрээнд арга хэмжээг авна. Үүнд:

Зорилт 6.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй холбоотой мэдээллийг багтаасан нэгдсэн мэдээллийн сантай болох

Долоодугаар зорилго. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг эрх мэдэлжүүлэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх, эрхээ бусдын адил эдлэх, шийдвэр гаргах түвшин дэх болон улс төрийн оролцоог нэмэгдүүлэх, мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангах цогц арга замыг тусгасан, хөгжлийн бэрхшээлийг тусгайлан авч үзсэн олон улсын анхны бичиг баримт юм. Манай улс конвенцид нэгдэн орж, соёрхон баталсан орны хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг олон улсын хуулиар баталгаажуулсан байна. Иймд одоо хэрэгжиж байгаа хууль тогтоомжуудад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ялгаварлан гадуурхахыг хориглосон заалт байгаа эсэхийг тодорхойлох шаардлагатай байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх мэдлэг, ойлголтыг нийгмийн бүх хүрээнд, ялангуяа тэдний гэр бүлийн хүрээнд нэмэгдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүний нэр төр, нандин чанарыг хүндэтгэснээр хүний эрхийг хангах боломжийг бүрдүүлнэ. Хөгжлийн бэрхшээлтэй хүн нь бусдын нэгэн адил эрх тэгш байх үндсэн дээр шүүх шатны бүх үйл ажиллагаанд хүртээмжтэй, үр дүнтэй оролцох эрхтэй. Энэ

эрхийг нь хангах үүднээс эрх зүйн чадамжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан тухайн хүний сонголт, хүсэл зоригт нийцсэн, эрхийг хүндэтгэсэн, сонирхлын зөрчилгүй, сөрөг нөлөөгүй хууль, эрх зүйн хамгаалалт чухал юм.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг шийдвэр гаргах үйл явцад оролцуулах, мөн нийгмийн гишүүний хувьд эрх, үүргээ биелүүлэх боломжийг тэдэнд бүрдүүлж өгөх нь Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хүндэтгэж байгаа хэрэг юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүн, тэдний төлөөллийн байгууллагууд улс төрийн болон шийдвэр гаргах бүх түвшинд илүү өргөн хүрээтэй оролцох оролцоог нэмэгдүүлэх, сонгох, сонгогдох эрхээ эдлэх, төрийн албанд томилогдох ижил тэгш, хүртээмжтэй орчныг бий болгох нь чухал юм.

Зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтуудын хүрээнд арга хэмжээг авна. Үүнд:

Зорилт 7.1. Хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх

Зорилт 7.2. Улс төрийн оролцоог нэмэгдүүлэх

Зорилт 7.3. Өөрөө өөтөө туслах бүлэг байгуулахыг дэмжих

Зорилт 7.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудыг чадавхжуулах

Зорилт 7.5. Ялгаварлан гадуурхахаас ангид байх чиглэлээр дотоодын хууль тогтоомжийг Олон улсын хууль тогтоомжтой нийцүүлэх

Зорилт 7.6. Хөгжлийн бэрхшээлтэй хүн бие даан шийдвэр гаргахад нь дэмжлэг үзүүлдэг тогтолцоог бий болгох

Наймдугаар зорилго. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг гамшгийн болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг нь хангах нөхцлийг бүрдүүлэх

Хөгжлийн бэрхшээлтэй хүн нь гамшгийн болзошгүй эрсдэлд өртөж амь насаа алдах, гэмтэж, илүү бэрхшээлтэй болж байгаа нь тэдэнд учирч байгаа гамшгийн аюулыг бууруулахад чиглэсэн бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр тогтолцоо байхгүйгээс үүдэлтэй юм. Олон нийтэд зориулсан үйлчилгээний зарлал, зардал нь ихэнхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжгүй байдлаар гарсан байдаг. Улсын хэмжээнд онцгой байдалд урьдчилан сэргийлэх сургуулилалт болон гамшгийн эрсдлийг бууруулах бусад арга хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг тогтмол оролцуулснаар гамшгийн үед гарах аливаа эрсдэл, хохирлоос урьдчилан сэргийлэх буюу бууруулах боломжтой юм.

Зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтын хүрээнд арга хэмжээг авна. Үүнд:

Зорилт 8.1. Гамшгийн үед хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст үүсч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, харилцан мэдээлэл дамжуулах нөхцлийг бий болгох

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хөтөлбөрийг ойрын болон дунд хугацааны 2 үе шаттайгаар 4 жилийн хугацаанд хэрэгжүүлнэ.

Нэгдүгээр үе шат буюу ойрын хугацаанд (2017-2018)

Хоёрдугаар үе шат буюу дунд хугацаанд (2019-2020)

Хөтөлбөрт дэвшүүлсэн зорилгын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТУУДЫН ХҮРЭЭНД ДАРААХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛНЭ:

Нэгдүгээр зорилго. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрүүл мэндийг боломжит дээд хэмжээнд хүргэх

Зорилт 1.1. Эрүүл мэндийг дэмжих

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдэд эрүүл амьдралын зуршил бий болгох сургалт зохион байгуулах;
- Эмч, эмнэлгийн ажилтнуудад хөгжлийн бэрхшээлийн талаар сургалт зохион байгуулах /ХБХ-ийн онцлог байдал, хүндэтгэн харилцах, ялгаварлан гадуурхахгүй байх гэх мэт сэдвээр/;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрүүл мэндийг дэмжих сурталчилгаа явуулах;
- Эмч, эмнэлгийн ажилтнуудад дохионы хэлний сургалт зохион байгуулах;
- Эрүүл мэндийн чиглэлээр ажилладаг сэтгүүлчдэд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар мэдээлэл өгөх;
- Эрүүл мэндийг дэмжих тараах материал, гарын авлагыг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй форматаар хэвлэх, түгээх /тухайлбал: Брайл, том үсгээр, ойлгоход хялбар зураг, дохионы хэл, уншдаг ном гэх мэт/;

Зорилт 1.2. Хөгжлийн бэрхшээлтэй болохоос урьдчилан сэргийлэх

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг скрининг үзлэгт хамруулж, дараах эрүүл мэндийн шатлалд илгээх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хоёрдогч хүндрэлд (арьс цоорох, шээсний замын халдвар, үений хязгаарлалт, таргалах, яс сийрэгших, сэтгэл зүйн хямралд орох г.м) орохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг хэрхэн гэрийн нөхцөлд авах талаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдэд сургалт зохион байгуулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хоёрдогч хүндрэлд орохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар эмч, эмнэлгийн ажилтнуудад сургалт зохион байгуулах;
- Төрөхийн өмнөх, төрөх үеийн, төрсний дараах эрсдлийг багасгах зорилгоор эцэг, эхчүүдэд сургалт зохион байгуулах;
- Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлж, хөгжлийн дэмжлэгт хамруулах загварыг боловсруулан, туршилтын төслийг 1 аймаг, 1 дүүрэгт хэрэгжүүлэх;
- Эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран гэр бүл, хамт олонд суурилсан эрт илрүүлгийн тогтолцоог хэрэгжүүлэн, бага насны хүүхдийг тодорхой хугацаанд эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулан хөгжлийн хоцрогдлыг нь илрүүлэх;
- Хөгжлийн хоцрогдол, бэрхшээлтэй хүүхдүүдийг хөгжлийн үнэлгээ, оношилгоонд хамруулж, үнэлгээг зохион байгуулах чадавхийг бүрдүүлэх;

Зорилт 1.3. Эмнэлгийн тусламж үйлчилгээг хүний эрхэд суурилсан хандлагаар хүргэх

- Хамт олонд түшиглэсэн үйлчилгээний стандартыг боловсруулах;
- Гуравдагч шатлалын эмнэлгээс архаг нөхцөл байдалд орсон, цаашид сэргээн засалтын тусламж үйлчилгээ шаардлагатай өвчтнийг илгээх хуудсаар анхдагч болон хоёрдогч шатлалын эрүүл мэндийн байгууллагуудад илгээх удирдамж боловсруулах;
- Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан эмнэлгийн сэргээн засалтын үйлчилгээг гэрээр үзүүлэх, хөнгөвчлөх эмчилгээ бий болгох;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуучууд, иргэдийг хамт олонд хамруулан хөгжлүүлэх хөгжлийн төвд ажиллах хөдөлгөөн, ахуйн, хэл заслын, мэргэжилтнүүд хиймэл эрхтэн, туслах хэрэгсэл хийх техникч нарыг бэлтгэх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс нь хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт үед нь илрүүлэн тогтоож, шаардлагатай хөгжлийн дэмжлэгийн төлөвлөгөө боловсруулах;
- Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг илрүүлэх скрининг оношлогооны тоног төхөөрөмж, эмнэлгийн хэрэгсэл, урвалж бодисоор хангах;

Зорилт 1.4. Туслах хэрэгслийн хүртээмжийг нэмэгдүүлэх

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст нэн шаардлагатай туслах хэрэгслийн жагсаалт болон жишиг үнийг шинэчлэх;
- Орон нутагт туслах хэрэгслийн хүртээмжийг нэмэгдүүлэх механизмыг бий болгох;
- Шаардлагатай тоног төхөөрөмж бүхий сэргээн засалтын туслах хэрэгслийг хийх жижиг оврын Ортопедийн цех байгуулах;
- Хиймэл эрхтэн хийх, энгийн туслах хэрэгслүүдийг хийх /техникчийг бэлтгэх байнгын болон түр сургалтуудыг зохион байгуулах;
- Үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг Сэргээн засалт, сургалт үйлдвэрлэлийн төвийн хиймэл эрхтэн, туслах хэрэгсэл хийдэг үйлдвэрийн тоног төхөөрөмжийг шинэчлэх;
- Туслах хэрэгслийг олгох тендерийн шалгаруулах комисст ТББ-ын төлөөллийг оролцуулах;

Зорилт 1.5. Чанартай сэргээн засалтын үйлчилгээ үзүүлэх

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эрт илрүүлж, сэргээн засч, хүний бие даасан байдлыг сайжруулж байгааг бүртгэлжүүлэх: маягтуудыг шинэчлэх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг сэргээн засах танхимд заавал байх хэрэгсэл, тоног төхөөрөмжийн жагсаалт гаргаж, хоёрдогч шатлалын эмнэлгүүд дээр тохижуулах (фитнесийн өрөө биш);
- Хөдөлгөөн засалч, ахуй засалч, хэл засалч зэрэг ажлын байрны тодорхойлолтыг гаргаж, хоёрдогч, гуравдагч шатлалын эмнэлгүүд дээр заавал ажиллуулах;
- Хөгжлийн хоцрогдолттой хүүхдийг эрт илрүүлж, шаардлагатай сэргээн засалтын арга хэмжээг эрт авах;
- Хүүхдийн эрт үеийн хөгжилд зориулсан тоглоом, номын сан, хүүхэд-эцэг эхчүүдийн сургалтын хэрэгслүүдээр хангах;

Зорилт 1.6. Хүртээмжтэй орчин бий болгох

- Эрүүл мэндийн байгууллагуудын орчны болон үйлчилгээний хүртээмжийн үнэлгээн дээр түшиглэн цаашид хүртээмжийг сайжруулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд “Ээлтэй хүртээмжтэй эмнэлэг” шалгаруулах болзолт уралдааныг зарлаж жил бүр тодруулж, урамшуулж байх;
- Хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүдэд нөхөн үржихүйн болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах /тухайлбал: эмэгтэйчүүдийн ор/, тэдний тусгай хэрэгцээг хангах;
- Эм, эмнэлгийн бүтээгдэхүүнүүдийн зааврыг харааны бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй болгох зорилгоор Брайлаар тайлбартай гаргах;
- Бүх шатны эмнэлэг, эрүүл мэндийн байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүнд туслах үйлчилгээ үзүүлдэг орон тооны ажилтантай болох;

- Бүх шатны эмнэлэгүүд угтах үйлчилгээндээ сонсголын бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх дохионы хэлний хэлмэрч бүхий хөтөчийг ажиллуулах;
- Яаралтай түргэн тусламжийн үйлчилгээнд зайн дүрс ярианы үйлчилгээ нэвтрүүлэх;

Зорилт 1.7. Хөгжлийн бэрхшээлийн олон улсын ангиллыг нэвтрүүлэх

- ICF-ийг нэвтрүүлсэн орнуудаас туршлага судлах;
- ICF-ийг орчуулах, хэвлэх;
- ICF-ийн талаар сургалт зохион байгуулах;
- ICF-ийг нэвтрүүлэх чиглэлээр туршилтын төсөл хэрэгжүүлэх;
- Хүүхдийн Эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын төв, салбар комисс болон Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын гишүүдийг хөгжлийн бэрхшээлийн тухай ойлголт болон, олон улсын ICF ангиллыг нэвтрүүлэх зорилгоор сургалтанд хамруулж бэлтгэх;

Зорилт 1.8. Эрүүл мэндийн бодлогын хүрээнд

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамт олонд түшиглэн сэргээн засах хандлагын эрүүл мэндийн салбарын удирдамж боловсруулах;
- Эрүүл мэндийн тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах /тухайлбал: удамшлын гаралтай нь тогтоогдсон үед үр хөндөх гэдэг заалтыг хасах г.м/;
- Сэтгэцийн бэрхшээлтэй хүмүүсийн олон улсын хүний эрхийн стандартын дагуу сэтгэцийн эрүүл мэндийн стратегийг тоймлон харж, ХОТСЗ төлөвлөгөө боловсруулах (институтийг тараах төлөвлөгөө гаргах);
- Өрх, сумын эрүүл мэндийн төвийн гэрийн сэргээн засах тусламж, үйлчилгээг ЭМД-аас санхүүжүүлэх эдийн засгийн тооцоо судалгааг хийж, холбогдох шийдвэрт тусган хэрэгжүүлэх;
- ЭМД-аас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалтыг өдрийн, гэрийн, урт хугацааны тусламж, үйлчилгээний чиглэлээр өргөтгөх асуудлыг судалж, шийдвэрлэх;
- Эмч, эмнэлгийн ажилтнуудыг бэлтгэдэг сургуулиудын хичээлийн хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн онцлог хэрэгцээнд тохируулсан хичээлийг оруулах (дохионы хэл, Брайл, нөхөн үржихүй гэх мэт);
- Эрүүл мэндийн чиглэлээр ажилладаг сэтгүүлч нарт мэдээлэл хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх мэдлэг ойлголт өгөх сургалтуудыг зохион байгуулах;

Хоёрдугаар зорилго. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг бүх шатны боловсролд тэгш хамруулах

Зорилт 2.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг боловсролын үйлчилгээнд хамрагдах нөхцөл боломжийг хангахад чиглэсэн эрх зүйн орчныг бүрдүүлэх

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролд хамрагдалтын одоогийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх /Нөхцөл байдлын судалгаа/;
- Сургуулийн өмнөх боловсрол олгож байгаа байгууллагын нэг багшид ногдох хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоог боловсролын нийгмийн хамгааллын, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран тогтоох;
- Тусгай болон сувиллын цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрэм, эрүүл ахуй, ариун цэврийн дүрмийг эрүүл мэнд, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, асрамжийн цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрмийг боловсролын болон нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батлах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багшид нэмэгдэл хөлс олгох асуудлыг шийдвэрлэх;
- Сургалтын орчинд тавигдах шаардлагыг баталгаажуулах;
- Цэцэрлэг, ЕБС-д хамрагдах хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах туслах багшийг ажиллуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх;

- Боловсролд тэгш хамруулан сургах хүүхэд бүрд хөгжлийн үнэлгээ хийх, ганцаарчилсан сургалтын үлгэрчилсэн хөтөлбөр боловсруулах, батлах;
- Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай нэг суралцагчид ногдох хувьсах зардлын норматив, тэдэнд зориулсан нэмэлт үйлчилгээний зардлыг шийдвэрлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох;
- Ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай суралцагчийн сурлагын амжилтыг үнэлэх үнэлгээний журам шинээр боловсруулах;
- Ерөнхий боловсролын тусгай сургуулийн хамран сургах тойрог тогтоох, аймаг, нийслэл, сум, дүүрэгт салбар бүлэг ажиллуулах, элсэлтийг зохион байгуулах журам боловсруулах;
- Их, дээд сургууль, коллеж, ерөнхий боловсролын сургуулийн суралцагч, цэцэрлэгт хүмүүжиж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тохирох хэрэглэгдэхүүн, сургалтын орчныг бүрдүүлэх журмыг боловсруулж, батлах;
- Багш бэлтгэдэг төрийн болон төрийн бус их, дээд сургуулиудын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрт “Тусгай хэрэгцээт боловсрол” хичээлийг заавал судлах агуулгад оруулах;
- Дохионы хэлний зөвлөлийг байгуулж, түүний ажиллах дүрмийг боловсруулж батлуулах;
- Дохионы хэлний хэлмэрч орчуулагчийг бэлтгэх журам боловсруулах;
- Брайль үсгийн стандартыг боловсруулах;

Зорилт 2.2. Сургуулийн өмнөх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бүрийг цэцэрлэгт хамруулах

- Цэцэрлэгт хүүхэд элсүүлэх зөвлөмжид хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг дараалал харгалзахгүй элсүүлэх чиглэлийг оруулж хэрэгжүүлэх;
- Сургуулийн өмнөх боловсролын багш нарт хөгжлийн бэрхшээлтэй бага насны хүүхдийг хөгжүүлэх, нөхөн сэргээх, засан сайжруулах, ахйу баримжаа олгох, эцэг эхэд зөвлөн туслах чиглэлээр сургалтын модулт боловсруулж, сургалт зохион байгуулах;
- Цэцэрлэг бүрт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйн ур чадвар бүхий хүний нөөцийг бэлтгэх;
- Хүүхдийн онцлог хэрэгцээнд нийцсэн ганцаарчилсан сургалтын хөтөлбөр боловсруулах арга зүйн сургалтыг багш нарт зохион байгуулах;
- Явуулын багшийн үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хүргэх ажлыг зохион байгуулах;
- Сонсголын бэрхшээлтэй хүүхдэд зориулсан эрт оролцооны хөтөлбөр хэрэгжүүлж, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангах ажлыг зохион байгуулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг СӨБ –д хөгжүүлэх хөгжлийн талаарх гарын авлага, удирдамжийг боловсруулж батлуулж хэвлэх;
- Сургуулийн өмнөх боловсрол олгож байгаа байгууллагын нэг багшид ногдох хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоог боловсролын нийгмийн хамгааллын, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран тогтоох;
- Тусгай болон сувиллын цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрэм, эрүүл ахуй, ариун цэврийн дүрмийг эрүүл мэнд, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, асрамжийн цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрмийг боловсролын болон нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батлах;
- СӨБ болон ЕБС-д хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажиллах туслах багшийн ажил үүргийг тодорхой болгох;

Зорилт 2.3. Хүүхдийн хөгжлийн онцлог хэрэгцээнд нийцүүлэн бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх

- Бага боловсролд хамрагдах хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын оношилгоо хийх арга зүйг боловсруулах, турших, хэрэгжүүлэх;

- Бага боловсролын түвшинд суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг нөхөн сэргээх, ганцаарчилсан сургалт явуулах танхимын загварыг байгуулах;
- Ерөнхий боловсролын сургуульд ажиллаж буй багш нарт зориулсан сургалтын модуль боловсруулж хэрэгжүүлэх;
- Боловсролд тэгш хамруулан сургах оюутан, суралцагч, бага насны хүүхдийн суралцах аюулгүй байдлыг хангах зорилгоор шат, хана, ариун цэврийн өрөө, суултуур, сургуулийн эзэмшил гадна зам, талбайг MNS6055:2009 стандартад заасны дагуу тохижуулах;
- БМДИ-ийн вебсайтад хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж буй багш нарт зориулсан байнгын ажиллагаатай булан ажиллуулах, Хос хэлний сургалтын арга зүйг хөгжүүлж, дохионы хэлээр ярих чадварыг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ хэрэгжүүлэх;
- Боловсролд тэгш хамруулан сургах хүүхэд бүрд хөгжлийн үнэлгээ хийх, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулах, зориулалтын орчин бүрдүүлэх;
- Боловсролд тэгш хамрагдан суралцагч хүүхдэд гарааны болон ахицын үнэлгээ хийх, ганцаарчилсан сургалтын хөтөлбөрийг боловсролын байгууллагын удирдлага, багш, эцэг эхийн оролцоотой боловсруулан хэрэгжүүлэх ажлыг эхлүүлэх, суралцагчийн суралцах боловсролын байгууллагыг сонгох эрхийг хүндэтгэн зөвшөөрөх талаар дүрэм, журам боловсруулж, хэрэгжүүлэх;
- Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай нэг суралцагчид ногдох хувьсах зардлын норматив, тэдэнд зориулсан нэмэлт үйлчилгээний зардлыг шийдвэрлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох;
- Ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай суралцагчийн сурлагын амжилтыг үнэлэх үнэлгээний журам шинээр боловсруулах;

Зорилт 2.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний мэргэжлийн болон дээд боловсрол эзэмших боломжийг нэмэгдүүлэх

- Мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, ирээдүйд эзэмших мэргэжлийг хүүхдийн хүсэл сонирхол, хөгжлийн бодит боломжид суурилж эзэмшүүлэх нөхцлийг бүрдүүлэх;
- Боловсролд тэгш хамруулан сургах оюутнуудыг амжилттай суралцахад тухайн сургууль дээр Оюутанд үйлчлэх төвд хөгжлийн бэрхшээлтэй оюутанд туслах ажилтан ажиллуулах чиглэл гаргаж мөрдүүлэх;
- Тусгай хэрэгцээт боловсролын багш, хэл засалч, хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч, дохионы хэлмэрч-орчуулагч, сэтгэл зүйчийг бакалавр, магистр, докторын түвшинд, гадаад, дотоодод шинээр бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалтад хамруулах;
- Багш бэлтгэдэг төрийн болон төрийн бус их, дээд сургуулиудын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрт “Тусгай хэрэгцээт боловсрол” хичээлийг заавал судлах агуулгад оруулах;
- Дээд боловсролын байгууллагууд суралцагчийн сонирхол, мэргэжлийн онцлогийг харгалзан хүртээмжтэй зориулалтын орчин бүрдүүлэх, төгсөгчдийг ажлын байраар хангахад ажил олгогчтой хамтран ажиллах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний магистр, докторын зэрэг олгох сургалтын зардлын хэмжээ, олгох журмыг боловсруулж, баталгаажуулах;
- Боловсролд тэгш хамруулан сургах оюутнуудыг амжилттай суралцахад тухайн сургууль дээр “Сургалтын материал, хэрэгсэлээр хангаж тохируулж бэлтгэж, шаардлагатай туслах үйлчилгээг үзүүлдэг дэмжих төв” ажиллуулах хөрөнгө, санхүүжилтийн эх үүсвэрийг сургуулийн стратеги, бодлого, санхүүжилтэд тусгаж хэрэгжүүлэх, санаачилж ажилласан сургуулийг төрөөс урамшуулах системийн тогтолцоог бий болгох, гадаадад суралцахад дэмжлэг үзүүлэх;
- Их, дээд сургууль, коллежид суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй оюутны тоог нарийвчлан гаргах мэдээллийн маягттай болох, аль нэг сургуулийн дэргэд хөгжлийн

бэрхшээлтэй оюутанд зориулсан тохирох хэрэглэгдэхүүнээр хангаж, үйлчилгээ үзүүлэх байгууллага бий болгох;

Зорилт 2.5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн амьдрах ухааны болон мэргэжлийн чиг баримжаатай болоход нь дэмжлэг үзүүлэх насан туршийн боловсролын үйлчилгээний загварыг хөгжүүлэх

- Насан туршийн боловсролын үндэсний төв, аймаг, дүүргийн Насан туршийн боловсролын төв, сумын нэгжүүдээр дамжуулан хэвтрийн, хүнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд бичиг үсгийн болон бага, суурь боловсрол эзэмшүүлэх ажлыг 2017-2018 оны хичээлийн жилээс эхлүүлэх, шаардлагатай тоног төхөөрөмжийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн байгаа орчинд суурилуулах зайн сургалтын тоног төхөөрөмж худалдан авах, суурилуулах, багшийн цалинг тооцож улсын төсөвт тусгах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах багш бэлтгэх, мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулах;
- Дүйцсэн хөтөлбөрөөр бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх сургалтыг үргэлжлүүлэх;
- Аймаг, дүүрэг дэх насан туршийн боловсролын төвийн зайн сургалтын тоног төхөөрөмжийг шинэчлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн байгаа орчинд байршуулах зайн сургалтын тоног төхөөрөмжийн болон суурилуулах зардлыг Улсын төсвийн хөрөнгө, төсөл, хөтөлбөрийн санхүүжилтээр үе шаттайгаар шийдвэрлэж байх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өөрт нь байгаа авьяас, ур чадвар, нөөц боломжид тулгуурлан мэргэжлийн чиг баримжаа олгож, амьдралд бэлтгэх;
- Өөртэй итгэлтэй байх хандлагыг хөхиүлэн дэмжиж, хүчирхэгжүүлэх зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах;

Зорилт 2.6. Хүртээмжтэй орчин бий болгох

- Сургалтанд ашиглагдаж буй ном сурах бичгийг хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын онцлог хэрэгцээнд нийцүүлэн хүртээмжтэй хэлбэрээр хэвлэх /аудио, видео, DVD, брайль, дүрс зурган өгүүлэмжтэй/;
- Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулиудад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сэргээн засч, хөгжүүлэх кабинетыг байгуулах, боловсон хүчнийг сургах;
- Боловсролд тэгш хамруулан сургах оюутан, суралцагч, бага насны хүүхдийн суралцах аюулгүй байдлыг хангах зорилгоор шат, хана, ариун цэврийн өрөө, суултуур, сургуулийн эзэмшил гадна зам, талбайг MNS6055:2009 стандартад заасны дагуу тохижуулах;
- Тусгай хэрэгцээт боловсролын багш, хэл засалч, хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч, дохионы хэлмэрч-орчуулагч, сэтгэл зүйчийг бакалавр, магистр, докторын түвшинд, гадаад, дотоодод шинээр бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалтад хамруулах;
- Суралцагчийн хөгжлийн бодит боломж, тэдний хүсэл сонирхол, хэрэгцээнд суурилсан сургалтын жишиг хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах, хэрэгжүүлэх;
- Монгол дохионы хэлний хэлмэрч, орчуулгын үйл ажиллагаа эрхлэх, үйлчилгээ үзүүлэх журмыг боловсруулах;
- Брайль үсгийн стандартыг боловсруулах;
- Тусгай сургууль, цэцэрлэгийн хүүхэд тээвэрлэх тусгай зориулалтын автобусыг шинэчилж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх;
- Бүх шатны боловсролын байгууллагуудад орчны болон сургалтын заах арга зүйг хүртээмжтэй болгоход чиглэгдсэн арга хэмжээг авах;
- Бүх номын санг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ээлтэй болгох;
- СЗСҮТ-ийн номын санг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй жишиг номын сан болгох;
- Сургууль дээр боломжит тохируулгыг (тохирох хэрэглэгдэхүүн) дэмжих;

Зорилт 2.7. ХБИ-ийг биеийн тамир, спорт, соёлын арга хэмжээнд татан оролцуулах, тэдний амьдралын зөв дадал хэвшилд сургах

- ХБИ-дэд зориулсан биеийн тамирын дасгал хөдөлгөөний жор, аргачлал боловсруулж, гарын авлага гаргах;
- ХБИ-ийн дунд нийтлэг спортын төрлүүдийг хөгжүүлэх, сургалт зохион байгуулах, сурталчилгаа хийх;
- Дотоодод зохиогдох Улсын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах, гадаадад оролцох тэмцээний тоо, санхүүжилтийг нэмэгдүүлэх;
- Тив, дэлхийн түвшинд өрсөлдөх тамирчдыг бэлтгэх;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг спортоор хичээллэх, дотоод, гадаадын уралдаан тэмцээнд оролцоход бэлтгэх зориулалтын хүртээмжтэй орчин, хэрэглэгдэхүүн бүхий заал, талбайгаар хангах;
- Багш дасгалжуулагч, боловсон хүчнийг бэлтгэх, чадавхжуулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн урлагийн их наадам, дүрслэх урлаг, гар урлалын бүтээлийн үзэсгэлэн, худалдааг дотоод болон гадаадад зохион байгуулах, оролцоход дэмжлэг үзүүлэх;

Гуравдугаар зорилго. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг сайжруулах

Зорилт 3.1. Ур чадварыг хөгжүүлэх

- МБСБ-уудын ажилтан албан хаагчдад хөгжлийн бэрхшээлийн талаар болон тохирох хэрэглэгдэхүүний мэдлэг ойлголт олгох сургалт зохион байгуулах;
- Бүх МСҮТ-үүд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст шинэ ур чадвар эзэмшүүлэх, мэргэжлийн чиг баримжааг олгодог байх;
- Хөдөлмөр, халамж үйлчилгээний чиглэлээр төрийн үйлчилгээ үзүүлдэг боловсон хүчин, мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтанд хамруулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэргэжлийн ур чадварын тэмцээнийг жил бүр зохион байгуулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэргэжлийн ур чадварын Дэлхийн болон Тивийн, ОУ-ын "Абилимп"-ийн тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлэх;

Зорилт 3.2. Хувиараа хөдөлмөр эрхлэх

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, төсвийн хөрөнгөөр хийх худалдан авалтанд тэргүүн ээлжинд хамруулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүн хөгжлийн бэрхшээлтэй хүнд ажил олгосон тохиолдолд, ажил олгогчийг нь дэмжлэгт хамруулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бизнесийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжих;

Зорилт 3.3. Цалинтай хөдөлмөр эрхлэх

- Ажил олгогч нарт сургалт зохион байгуулах /ажлын байрыг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн онцлог байдалд нийцүүлж тохируулах/;
- Хөдөлмөрийн хуулийн хэрэгжилтийн хяналтын механизмыг сайжруулах;
- ХБИ-ийн ажил эрхлэлтийн журмыг мөрдөж байгаа үйл явцад хяналт шинжилгээ хийхэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог нэмэгдүүлэх;
- Төрийн байгууллага, хуулийн этгээд нь ажлын байрны нээлттэй сонгон шалгаруулалтыг зарлаж, шалгахдаа хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээнд тохируулж хүртээмжтэй хэлбэрээр зохион байгуулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамруулсан бизнесийн үйл ажиллагааг дэмжих (худалдаа, үйлчилгээ, үйлдвэрлэл);

Зорилт 3.4. Санхүүгийн үйлчилгээ

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байртай болгоход дэмжлэг үзүүлэх;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг сайжруулж, хамрах хүрээг оновчтой болгох, санхүүгийн буцалтгүй тусламж,

барьцаагүй, хөнгөлттэй зээлийн үйлчилгээ бий болгох, ТББ-уудын хяналт оролцоог нэмэгдүүлэх;

Зорилт 3.5. Ажлын байрыг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй болгох, тохируулгатай ажлын байраар хангах

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ажиллах орчны стандартыг боловсруулж, батлах
- Тохируулгатай ажлын байр бий болгоход “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан”-аас дэмжлэг үзүүлэх;
- Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгоход ашиглах гарын авлага, түгээмэл мэргэжил бүрээр танилцуулгыг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй форматаар хэвлэж, бэлтгэх;

Зорилт 3.6. Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хүрээнд

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын стратегийг сайжруулж, шинэчилэн боловсруулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн төслийг боловсруулж батлуулах;
- ХБИ-ийг үнэлэх, тохирох мэргэжлийг сонгох зөвлөх үйлчилгээг нэвтрүүлэх;
- Сайн туршлагыг сурталчлах олон нийтийн арга хэмжээг зохион байгуулах;
- ХБИ-ийг ажилд зуучлах үйл ажиллагааг боловсронгуй болгож, ХБХ-т боломжит ажлын байр санал болгох нөхцлийг бүрдүүлэх;
- ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлт, судалгаа, хөгжлийн төв байгуулах;
- Мэргэжлийн боловсрол олгох сургалтын байгууллагын бүх сургалтын хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүнийг сургах агуулга, арга зүйг тусган боловсруулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хөдөлмөрт бэлтгэх механизм бий болгох /Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 10-р зүйлийг хэрэгжүүлэх/;
- Хөдөлмөрийн биржүүдийн үйл ажиллагааг хүртээмжтэй болгох;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ажил санал болгох, зуучлах үйлчилгээг сайжруулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны сургалтын модуль, хөтөлбөр боловсруулах;
- Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны Сургагч багш бэлтгэх;
- Хувь хүний хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны хөтөлбөр боловсруулах;
- Худалдаа аж үйлдвэрийн тэнхимээс гадаадад явдаг бизнесменүүдийн дунд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн төлөөллийг оролцуулах;

Дөрөвдүгээр зорилго. Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах

Зорилт 4.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бие даан амьдрахад чиглэгдсэн үйлчилгээг хөгжүүлэх

- Бие даан амьдрахад чиглэгдсэн үйлчилгээний журмыг боловсруулж, батлуулах;
- Хөтөч нохойн үйлчилгээний журмыг боловсруулж батлуулах;
- Хөтөч нохойн үйлчилгээг хэрэгжүүлэхтэй холбоотой гадаад улсаас сургагч багшийг урьж, дотоодод мэргэжилтэн бэлтгэж, загвар төслийг хэрэгжүүлэх;
- Харааны бэрхшээлтэй иргэдэд хөтөч нохойн туслах үйлчилгээ үзүүлэх туршилтын төслийг хэрэгжүүлэх;

Зорилт 4.2. Хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээг сайжруулах

- Хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээний стандартыг боловсруулж, батлуулах;
- Хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээг журмын дагуу төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлэх;

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдийг хамт олонд хамруулан хөгжүүлэх хөгжлийн төвийг бүсчилсэн байдлаар 6 аймагт барих /Ховд, Хөвсгөл, Дорнод, Дундговь, Архангай, Дархан-Уул, Дундговь/;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдийг хамт олонд хамруулан хөгжүүлэх хөгжлийн 6 төвийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг тусгай институтийн (асрамжийн газар) хандлагыг өөрчлөх дунд хугацааны төлөвлөгөө боловсруулах;

Зорилт 4.3. Нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлчилгээ, тоног төхөөрөмжийн хүртээмжийг сайжруулахын тулд шалгуурыг оновчтой тогтоох, санхүүжилтийг нэмэгдүүлэх замаар нийгмийн халамжийн тогтолцоог шинэчлэх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний асран хамгаалагч нарын нөхцөл байдлын талаарх судалгаа хийж, бодлогын түвшинд дэмжих;

Тавдугаар зорилго. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст саадгүй орчин, нийтийн тээвэр, мэдлэг, мэдээлэл, харилцааны хүртээмжийг сайжруулах

Зорилт 5.1. Барилга, зам, нийтийн тээврийн хүртээмжийг сайжруулах

- Барилга, зам, нийтийн тээвэртэй холбоотой стандартуудын нийцэл хоорондын уялдаан дээр үнэлгээ хийж, Монгол Улсын стандартыг олон улсын стандарттай нийцүүлэх;
- (1) Зам тээврийн дэд бүтцэд үнэлгээ хийх (үүнд: галт тэрэгний буудал, нисэх онгоцны зорчигч тээврийн буудал, бусад буудлууд, гудамжны дэд бүтэц); (2) Олон нийтийн барилга байгууламжид үнэлгээ хийх (үүнд: сургууль, эмнэлэг, нийгмийн үйлчилгээ, хоргодох байр, болон олон нийтэд үйлчилдэг бусад байгууламж);
- Үнэлгээний тайлангууд дээр үндэслэн: (1) Стандарттай нийцүүлэн барилга, байгууламжинд засвар хийх (2) Хүртээмжтэй болгохын тулд тодорхой газруудад шинэ үйлчилгээг бий болгох;
- Түгээмэл загварын талаарх мэдлэг ойлголтыг барилга архитектур техникийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг их дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт тусгуулах;
- Дэд бүтцийн норм, стандарт, хууль тогтоомжийг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг эрхэлдэг байгууллагууд болон шийдвэр гаргагчдын чадавхийг дээшлүүлэх (дэд бүтэц, зам тээвэр, мэдээлэл);
- MNS 5682:2006 стандартыг шинэчлэн боловсруулах, зарим өөрчлөлт оруулах
- Хорооллын доторх зам, гэр хорооллын гудамжны замын стандартыг шинээр боловсруулах;
- Нийтийн тээврийн үйлчилгээний журам, техникийн нөхцлийг сайжруулах;
- Барилга, зам хүлээж авах, зураг төсөл баталдаг коммист хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн төлөөллийг оруулах;
- Хүртээмжийн тухай хуулийн төсөл боловсруулж батлуулах;
- Төмөр зам, агаарын тээвэр, нийтийн тээврээр хөгжлийн бэрхшээлтэй хүнд үйлчилдэг Тусгай үйлчилгээ (SOS) үйлчилгээг нэвтрүүлэх;

Зорилт 5.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст мэдээллийн технологийн хүртээмжийг сайжруулах

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний мэдээллийн хүртээмжийн талаарх хууль эрх зүйн орчин боловсронгуй болгож холбогдох хуулиудад нэмэлт өөрчилөлт оруулах;
- Мэдээллийн хүртээмжийн талаарх олон улсын стандартуудыг судалж, өөрийн орны стандартуудыг шинэчлэн боловсруулах;
- Яам, агентлагуудын вэб сайтуудыг ХБХ-т хүртээмжтэй болгох;
- Зайн дүрс ярианы үйлчилгээний олон улсын стандартыг туршиж нэвтрүүлэх;
- Дэлгэц уншигч, гар утасны болон бусад цахим хэрэгслийн программыг ХБХ-ийн хэрэгцээнд тулгуурлан монгол хэл дээр зохион бүтээх, нэвтрүүлэх;

- Монголын үндэсний олон нийтийн телевиз болон бусад арилжааны телевизийн хөтөлбөрийг (мэдээллийн, танин мэдэхүйн хөтөлбөр) дохионы орчуулгатай, уран сайхны киног хадмал орчуулгатай болгох;
- Монголын үндэсний олон нийтийн телевизийн Үндэсний зөвлөлд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл орох;
- Хүүхдийн нэвтрүүлэгүүдийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд хүртээмжтэй хэлбэрээр хийх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенц, Нэмэлт Протокол, Инчеоны стартеги болон бусад олон улсын гэрээ конвенцийг Монгол хэл дээр албан ёсоор орчуулж, бар кодтой болгож, брайл үсгээр хэвлэх, дохионы хэлээр хөрвүүлж гаргах, тараах;
- Олон нийтэд болон төрийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд, худалдаа, үзвэр үйлчилгээний салбарынханд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн орчны болон үйлчилгээний, мэдээллийн хүртээмжийн талаар ойлголт өгөх нөлөөлийн ажлыг хийх;
- Улсын хэмжээнд байгаа номын сангуудын номын фондыг ХБХ-т хүртээмжтэй номоор баяжуулах /Брайль стандарт болон уншихад хялбар, аудио хэлбэрээр, дохионы хэлээр хөрвүүлж гаргасан номоор баяжуулах/;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хандах олон нийтийн хандлагыг өөрчлөх талаар тусгайлсан цагтай болох;
- Сонсголгүй Иргэдийн Мэдээллийн төвийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж хамтран ажиллах;

Зургадугаар зорилго. Хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх харьцуулж болохуйц, үнэн бодит тоон мэдээллийг бий болгох

Зорилт 6.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй холбоотой мэдээллийг багтаасан нэгдсэн мэдээллийн сантай болох

- www.1212.mn Статистикийн мэдээллийн нэгдсэн санд хөгжлийн бэрхшээлийн статистикийг оруулах;
- Хүн ам, орон сууцны тооллогын асуумжинд Вашингтоны бүлгийн асуулгын дагуу хөгжлийн бэрхшээлийн талаарх асуултыг тусгах ;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн судалгаа авах аргачлалыг нэгдсэн байдлаар гаргах, эх сурвалжийг тодорхой болгох Тоо баримт цуглуулахыг тодорхойлох арга, аргачлалыг боловсруулж холбогдох байгууллагуудад түгээх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн мэдээллийн сантай болох (найдвартай тоо баримт цуглуулах, бодит байдлыг тодорхойлох, бодлогыг тодорхойлоход тэрхүү тоог ашиглах, Инчеоны стратегийн зорилтын хүрээнд ашиглах);
- Өрхийн орлогын амьжиргаа түвшин, ажил эрхлэлтийн судалгаа хийх;
- Ази номхон далайн орнуудаас туршлага судлах, уулзалт, сургалт зохион байгуулах;

Долоодугаар зорилго. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг эрх мэдэлжүүлэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх, эрхээ бусдын адил эдлэх, шийдвэр гаргах түвшин дэхь болон улс төрийн оролцоог нэмэгдүүлэх, мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх

Зорилт 7.1. Хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх

- Хүчирхийлэлд өртсөн хөгжлийн бэрхшээлтэй охид эмэгтэйчүүдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх, зөв харилцааны талаарх сургалтыг цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажилтан, нийгмийн ажилтан, эмч, бусад холбогдох албаны хүмүүст зохион байгуулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст гэр бүлийн хүчирхийлэл болон зөрчигдсэн эрхээ хэрхэн хамгаалах талаарх гарын авлагыг хэвлэн тараах, хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр сурталчлан таниулах;

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, хүүхдийн хөгжлийн төвийг барьж байгуулах, уг төв дээр тулгуурлан хууль тогтоомж сурталчлах үйл ажиллагааг улирал тутам зохион байгуулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийн 12-р зүйл болон бусад тусгайлсан эрхийг хэрэгжүүлэхэд оролцогч шүүгч, өмгөөлөгч болон хууль зүйн мэргэжлийн бусад хүмүүст сургалт явуулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй залуу манлайлагчдыг бэлтгэх сургалтыг зохион байгуулах;
- Одоо байгаа хамгаалах байрыг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй болгох;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй оны шилдэг хүртээмжтэй байгууллагуудыг шалгаруулах /жилд нэг удаа/;
- Хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдээллийн компанит ажлыг зохион байгуулах;

Зорилт 7.2. Улс төрийн оролцоог нэмэгдүүлэх

- Хөгжлийн бэрхшээлтэй сонгогчийн сонгуулийн боловсролыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах, сонгууль зохион байгуулж байгаа хүмүүст мэдлэг олгох;
- Сонгуулийн хууль, журам, болон улс төрийн эрхийн талаарх материал (брошур, тараах хуудас)-ыг хүртээмжтэй, ойлгоход хялбар форматаар хэвлэн, тараах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг сонгуулиа чөлөөтэй өгөхөд зориулж хүртээмжтэй сонгуулийн байраар хангах;
- Сонгуулийн хуудсыг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн онцлог хэрэгцээнд тохируулж хүртээмжтэй хэлбэрээр хэвлэх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний сонгогдох эрхийг хангах хүрээнд Улс төрийн намуудын тухай хууль, Сонгуулийн тухай хуулинд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн квотыг бий болгох;

Зорилт 7.3. Өөрөө өөтөө туслах бүлэг байгуулахыг дэмжих

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өөрөө өөртөө туслах бүлгүүдийг байгуулахад анхан шатнаас дэмжиж, өргөжүүлэх, хөтөлбөрүүдэд хамруулах;

Зорилт 7.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудыг чадавхжуулах

- Төрийн бус байгууллагын гишүүдийг чадавхжуулах сургалтуудыг зохион байгуулах;

Зорилт 7.5. Ялгаварлан гадуурхахаас ангид байх чиглэлээр дотоодын хууль тогтоомжийг Олон улсын хууль тогтоомжтой нийцүүлэх

- Хүчин төгөлдөр үйлчилж буй дотоодын хууль тогтоомжуудад хөгжлийн бэрхшээл, хүйс, нийгмийн байдал болон бусад хүчин зүйлийн улмаас хүнийг ялгаварлан гадуурхсан заалт буй эсэхэд үнэлгээ хийх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулинд ялгаварлан гадуурахыг хориглох талаар нэмэлт өөрчлөлтийг тусгах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг сурталчлах олон нийтийг хамарсан үйл ажиллагааг жил бүр зохион байгуулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, холбогдох хууль эрх зүйг сурталчлах сургагч багш бэлтгэх;
- Бэлтгэгдсэн сургагч багш нар нь шийдвэр гаргах түвшин, ажил олгогч, ХБХ-ийн гэр бүлийн гишүүд, үйлчилгээний ажилтнуудад сургалт зохион байгуулах;

Зорилт 7.6. Хөгжлийн бэрхшээлтэй хүн бие даан шийдвэр гаргахад нь дэмжлэг үзүүлдэг тогтолцоог бий болгох

- Дэмжлэгтэйгээр шийдвэр гаргах чиглэлээр олон улсын туршлагыг судалж, энэ чиглэлийн туршилтын төслийг Монгол улсад хэрэгжүүлэх зөвлөмжийг гаргах;
- Дэмжлэгтэйгээр шийдвэр гаргах чиглэлээр туршилтын төслийг 2 газарт дараах зорилтот бүлэгт хэрэгжүүлэх. Үүнд: Оюун ухааны бэрхшээлтэй болон нийгэм-сэтгэцийн бэрхшээлтэй хүмүүс (УБ болон нэг дүүрэг);

Наймдугаар зорилго.Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг гамшгийн болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг нь хангах нөхцлийг бүрдүүлэх

Зорилт 8.1. Гамшгийн үед хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст үүсч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, харилцан мэдээлэл дамжуулах нөхцлийг бий болгох

- Гамшгийн эрсдлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр, түүний хэрэгжилтийг хангах төлөвлөгөөнд тусгагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн гамшигийн эрсдлийг бууруулах арга хэмжээний хэрэгжилтийг сайжруулах;
- Гамшгийн эрсдлийн үед хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй ажиллах арга барилыг эзэмшүүлэх сургалтыг онцгой байдлын ажилтнуудын дунд зохион байгуулах;
- Онцгой байдлын үед хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хүртээмжтэй дохио өгөх системийг бий болгох туршилтын төслийг хэрэгжүүлэх;
- Гамшгаас өөрийгөө хамгаалах арга зүйг тусгасан гарын авлагыг хүртээмжтэй форматаар хийж тараах;
- Яаралтай түргэн тусламжийн үйлчилгээг хөгжлийн бэрхшээлийн онцлог хэрэгцээнд тохируулан үзүүлэх;

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХӨТӨЛБӨРИЙН ҮР НӨЛӨӨ, БҮТЭЭГДЭХҮҮН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Үндэсний хөтөлбөр нь дараах үр нөлөө, шалгуур үзүүлэлттэй байна. Үүнд:

Нэгдүгээр зорилго. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрүүл мэндийг боломжит дээд хэмжээнд хүргэх

Үр нөлөө

Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч нарын хандлага өөрчлөгдөнө.

Эрүүл мэндийн байгууллагуудын орчны болон үйлчилгээний хүртээмж сайжирна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдийн эрүүл мэндийн мэдлэг нэмэгдэнэ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэнд, сэргээн засалт, тусламж үйлчилгээнд хамрагдалт нэмэгдэнэ.

Шалгуур үзүүлэлт

- Эрүүл мэндийн зөв дадал эзэмших сургалтанд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо
- Чанартай сэргээн засалтын тусламж үйлчилгээ авсан хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо
- Өөрийн хэрэгцээнд тохирсон туслах хэрэгсэлтэй болсон хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо
- Орчны болон үйлчилгээний хүртээмжтэй эрүүл мэндийн байгууллагуудын тоо
- Сургалтанд хамрагдсан эмч, эмнэлгийн ажилтны тоо

Хоёрдугаар зорилго. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг бүх шатны боловсролд тэгш хамруулах

Үр нөлөө

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн бүх шатны боловсролд хамрагдалт нэмэгдэнэ.

Шалгуур үзүүлэлт

- Боловсролгүй хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо
- Бага боловсрол эзэмшсэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо
- Суурь боловсрол эзэмшсэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо
- Бүрэн дунд боловсрол эзэмшсэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо
- Техник мэргэжлийн боловсрол эзэмшсэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо
- Тусгай мэргэжлийн дунд боловсрол эзэмшсэн хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо
- Дээдболовсрол эзэмшсэн хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо
- Цэцэрлэгт хамрагдсан 2-5 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо
- Сургуульд хамрагдсан 6-29 насны хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо

Гуравдугаар зорилго. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг сайжруулах

Үр нөлөө

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт нэмэгдэнэ.

Шалгуур үзүүлэлт

- 15 түүнээс дээш насны хөдөлмөр эрхэлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо
- Цалинтай хөдөлмөр эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо
- Хувиараа хөдөлмөр эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо
- Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогчийн тоо
- Хөгжлийн бэрхшээлтэй ажил олгогчийн тоо
- Хөдөлмөрийн биржэд бүртгэлтэй хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо
- Бизнес инкубаторт бойжиж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо
- Хөгжлийн бэрхшээлтэй ажил олгогч хөгжлийн бэрхшээлтэй хүндээ ажил олгосон байгууллагын тоо
- Засгийн газрын санхүүжилттай мэргэжлийн сургалтууд болон бусад хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн хөтөлбөрүүдэд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо
- Ядуурлын түвшнээс доогуур амьдарч байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо
- Өдөрт 1.25 ам.доллараар (Дэлхийн банкны тодорхойлсноор) амьдардаг хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо

Дөрөвдүгээр зорилго. Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах

Үр нөлөө

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээнд суурилсан нийгмийн хамгааллын үйлчилгээг авч, бие даан амьдрах боломж бүрдэнэ.

Шалгуур үзүүлэлт

- Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнээс үйлчилгээ авч буй хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо
- Хувийн туслах үйлчилгээ авсан хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо

Тавдугаар зорилго. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст саадгүй орчин, нийтийн тээвэр, мэдлэг, мэдээлэл, харилцааны хүртээмжийг сайжруулах

Үр нөлөө

Хөгжлийн бэрхшээлтэй хүн нь бусдын нэгэн адил нийгмийн харилцаанд эрх тэгш оролцоно.

Шалгуур үзүүлэлт

- Хүртээмжтэй нийтийн барилга байгууламжийн тоо
- Хүртээмжтэй нийтийн тээврийн хэрэгслийн тоо
- Орон сууц, нийгмийн дэд бүтцийг хүлээн авах хороо, комисст ажиллаж байгаа ХБХ-ийн төлөөлөл
- А зэрэглэлийн буюу 17 дээш давхарын барилгууд дээр барилгын ажил хүлээж авах Улсын комисст ажиллаж байгаа ХБХ-ийн төлөөлөл
- Гол мэдээний хөтөлбөрүүдийг дохионы хэл дээр болон тайлбар бичигтэй явуулж буй телевизийн сувгуудын тоо

Зургадугаар зорилго. Хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх харьцуулж болохуйц, үнэн бодит тоон мэдээллийг бий болгох

Үр нөлөө

Найдвартай, олон улстай харьцуулах хөгжлийн бэрхшээлийн статистикийг боловсруулж, нийтэлнэ.

Шалгуур үзүүлэлт

Нас, хүйс, хөгжлийн бэрхшээлийн төрөл, нийгмийн хамгаалалд хамрагдсан байдлаар гэх мэтээр гаргасан олон улсын түвшинд харьцуулж болохуйц мэдээллийн сантай болсон байна.

Долоодугаар зорилго. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг эрх мэдэлжүүлэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх, эрхээ бусдын адил эдлэх, шийдвэр гаргах түвшин дэхь болон улс төрийн оролцоог нэмэгдүүлэх, мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх

Үр нөлөө

Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ялгаварлан гадуурхахгүй байх хандлага бий болсон байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх мэдлэг ойлголт нийгмийн түвшинд нэмэгдсэн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоо нэмэгдсэн байна.

Шийдвэр гаргах түвшинд хөгжлийн бэрхшээлтэй хүний оролцоо нэмэгдсэн байна.

Шалгуур үзүүлэлт

- ХБХ-ийн УИХ-ын гишүүдийн дунд эзлэх хувь
- ХБХ-ийн аймаг, дүүргийн ИТХ, баг, хорооны ИНХ-д дунд эзлэх хувь
- Үндэсний түвшинд засгийн газрын танхимд ажиллаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тоон харьцаа
- Шийдвэр гаргах түвшинд оролцож байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо
- Төрийн байгууллагад ажиллаж байгаа ХБХ-ийн тоо
- УИХ-ын сонгуульд оролцсон ХБХ-ийн тоо
- Идэвхтэй ажиллаж байгаа ХБИБ-ын тоо
- Жендэрийн эрх тэгш байдал ба эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлэх асуудал хариуцсан үндэсний тогтолцоонд төлөөлж буй хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо

- Хөгжлийн бэрхшээлтэй сонгогчдын саналын нууцлалыг хадгалах үйл явц нь хүртээмжтэй нийслэл хотод буй сонгуулийн саналынбайрны тоон харьцаа
- Ойлголт нэмэгдүүлэх сургалтанд хамрагдсан төрийн байгууллагын ажилтнуудын тоо
- Ойлголт нэмэгдүүлэх сургалтанд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо
- Хүчирхийлэлд өртсөн хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүдийн тоо
- Гэр бүлийн хүчирхийлэл болон зөрчигдсэн эрхээ хамгаалуулахаар хууль зүйн туслалцаа авсан хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо

Наймдугаар зорилго.Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг гамшгийн болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг нь хангах нөхцлийг бүрдүүлэх

Үр нөлөө

Гамшгийн эрсдлийн үед хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн аюулгүй байдал нэмэгдэнэ.

Шалгуур үзүүлэлт

- Сургалтанд хамрагдсан ажилтнуудын тоо
- Гамшгийн үед тусламж авсан хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо

ТАВДУГААР БҮЛЭГ. ТӨСӨВ, САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР

Хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээ, үйл ажиллагааг дараах хөрөнгийн эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

- Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт;
- Олон улсын байгууллага, хандивлагч орны зээл, тусламж

Жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын жилийн төсвийн төлөвлөлтийн явцад санхүүжилтийн дэлгэрэнгүй төлөвлөгөөг гаргах шаардлагатай. Энэхүү хөтөлбөрт заасан байгууллага тус бүр дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн хүрээнд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг төлөвлөнө.

2016 оны 6 дугаар сард Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан төслийг хэрэгжүүлэхээр Монгол Улсын Засгийн газар /ХНХЯ/ Азийн Хөгжлийн Банктай 25 сая ам.долларын Харилцан ойлголцох санамж байгуулсан ба үүнээс 2 сая ам.доллар нь Японы ядуурлыг бууруулах сангийн техник туслалцаа, 23 сая ам.доллар нь АХБ-ны хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэртэй байх юм. Төсөл нь 2017-2022 онд хэрэгжинэ.

ХНХЯ нь Жайка ОУБ-ын “УБ хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих” төслийн нээлтийг хийсэн. Уг төсөл нь 2017-2020 онуудад хэрэгжих ба 7 сая ам.долларын өртөгтэй байна.

БСШУСЯ, ХНХЯ хамтран ЖАЙКА ОУБ-ын “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах” төслийг 2016-2020 онуудад хэрэгжиж байгаа бөгөөд 1 тэрбум 400 сая төгрөгийн өртөгтэй байна.

FLOM Финляндын төрийн бус байгууллага Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудтай хамтран төсөл хэрэгжүүлж байна.

АИФО Италийн төрийн бус байгууллага Монгол улсад 1991 оноос хойш Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамт олонд түшиглэн сэргээн засах хандлагыг хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулж, ЭМЯ, ХНХЯ-тай хамтран ажиллаж байна. 25 жилийн хугацаанд Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамт олонд түшиглэн сэргээн засах “Тэгш Дүүрэн” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлсэн.

НҮБ-ын Юнеско байгууллага нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг олон нийтэд сурталчилах, хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх чиглэлээр ХНХЯ-тай хамтран ажиллаж байгаа бөгөөд 2017 онд 30 сая төгрөгийн төсөл хэрэгжүүлж байна.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

6.1 Хяналт шинжилгээ, үнэлгээ хийх байгууллага, нэгтгэн тайлагнах хугацаа

1. Төрийн захиргааны төв байгууллагууд, Засгийн газрын хэрэгжүүлэгч болон тохируулагч агентлагууд, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, иргэний нийгмийн байгууллагууд дараа жилийн 02 дугаар сарын 20-нд багтаан хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг, хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөгөөний шалгуур үзүүлэлтийн дагуу Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.
2. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн тайланг гаргана. Хөтөлбөрийн нэгдсэн тайланд үндэслэн хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүнг 04 сарын 1-ний дотор Засгийн газар, ХБХ-ний эрхийг хангах Үндэсний зөвлөлд жил бүр танилцуулна.
3. Хөгжлийн бэрхшээлийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 10.7-р заалтын дагуу үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ ажлыг тусган хийж, хоёр жил тутамд хөндлөнгийн үнэлгээг хийлгэх ажлыг зохион байгуулж, тайлан тус бүрийг Засгийн газарт танилцуулна.
4. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжид үндэслэн хэрэгжилтийг эрчимжүүлэх, нэмэлт өөрчлөлт оруулах шаадлагатай арга хэмжээг авах үйл ажиллагааг Хөгжлийн бэрхшээлийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцан гүйцэтгэнэ.
5. Хөтөлбөрийг 2017-2020 оныг хамруулан 2017-2018 онууд, 2019-2020 онуудад хоёр үе шаттайгаар хэрэгжүүлэхдээ дараах үнэлгээг хийнэ. Үүнд:
 - Явцын үнэлгээг 2018 оны 4-р улиралд
 - Төгсгөлийн үнэлгээг 2021 оны 2-р улиралд
6. Хөгжлийн бэрхшээлийн асуудлаар мэргэшсэн судалгааны байгууллага, багаар гэрээний үндсэн дээр хөтөлбөрийн хэрэгжилтэд 2 жилд нэг удаа хөндлөнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх бөгөөд тайланг Засгийн газарт танилцуулна.

6.2 Хяналт шинжилгээ, үнэлгээний үр дүн, санал зөвлөмжийг хэрэгжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагаа

1. Хөтөлбөрийн явцын үнэлгээ хийж, гарсан үр дүн, санал зөвлөмжийн дагуу Төрийн захиргааны төв байгууллагууд, Засгийн газрын хэрэгжүүлэгч болон тохируулагч агентлагууд, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, иргэний нийгмийн байгууллагууд хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлнэ.
2. Хяналт шинжилгээ, үнэлгээний төгсгөлийн шатны үр дүн нь дараагийн хөтөлбөр боловсруулах үндэслэл болно.